

АЛСЫН ХАРАА
2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ НИЙГЭМ

7

2050
—
مستقبل

—
ᠠᠮᠠᠷ ᠲᠠᠶᠠᠨ,
ᠠᠶᠤᠯᠦᠭᠦᠢ ᠨᠢᠶᠭᠡᠮ
—



АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО



АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.



АЛСЫН ХАРАА
2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Ерөнхий редактор:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Баянгэрэлийн БАТБААТАР

Редакцын баг:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Даваадоржийн ЭНХБОЛДБААТАР
Өлзийбүрэнгийн ЖАМЪЯН
Боргилын НОМИН

Зөвлөх:

Баярсайханы СОЛОНГОО
Бадарчийн НАРМАНДАХ
Борын ЭРДЭНЭЧИМЭГ
Даваасүрэнгийн БОЛОР-ЭРДЭНЭ
Батцэнгэлийн БОЛОР-ЭРДЭНЭ
Нэргүйн МЯГМАР

Дизайнер:

Нямжавын БЯМБАЦОГТ
Жаргалсайханы МӨНХСАЙХАН

Гэрэл зураг:

МРА.МН
Жамбалын БАТБААТАР /БАКУ/
Хишигтогтохын ТҮШИГ

Хавтасны зураг:

Батбаатарын ЦОЛМОНБАЯР

Улаанбаатар хот 2022 он

Copyright © ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан болно. Бүтээлийг ашгийн бус зорилгоор олон нийтэд түгээх, хуваалцах, ашиглах, хэрэглэх эрхтэй бөгөөд гагцхүү эх сурвалжийг дурдана уу.

Хэвлэлийн эхийг Нэпко хэвлэлийн газарт бэлтгэж,
"Мөнхийн үсэг" ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-511-63-0



ГАРЧИГ

ШИНЭ СОРИЛТЫН ӨМНӨХ МОНГОЛ	8
ЗЭВСЭГТ ХҮЧИН	14
ДАРХАН ХИЛ	28
ХҮН, НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ	40
ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ХӨГЖИЛ	48
МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	56

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлнэ гэж заасан. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга замыг оршин тогтнохуйн, эдийн засгийн, дотоод, хүн, нийгмийн, хүрээлэн байгаа орчны, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхойлон хэрэгжүүлж байна.


Уламжлалт ойлголтоор, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны гол объект нь “улс” бөгөөд “улсын аюулгүй байдал” нь тусгаар тогтнол, бүрэн эрхт ба газар нутгийн бүрэн бүтэн байдал зэрэг суурь асуудлуудаар илэрхийлэгдэж байсан бол өнөө цагт эдгээрээс гадна улс төр, эдийн засгийн тогтвортой, өсөлттэй байдал, нийгмийн хамгаалал, хүний хөгжлийн боломж, эрх чөлөө, эрсдэлээс хамгаалагдсан амьдрах орчин нөхцөл, кибер аюулгүй байдал зэрэг олон хүчин зүйлийн нийлэмжээр амар амгалан, аюулгүй байдал цогцлон бүрдэж байна.

Монгол Улс 2019 оны байдлаар Дэлхийн энх тайвны үзүүлэлтээр 163 улсаас 40 дүгээрт, Даяаршлын үзүүлэлтээр 208 улсаас 79 дүгээрт, кибер аюулгүй байдлын үзүүлэлтээр 2020 онд 188 орноос 120 дугаар байранд эрэмбэлэгдэж байна.

Манай улс газар нутгийн байршлаар ОХУ, БНХАУ-ын хооронд орших боловч засаглалын оновчтой бүтэц, дипломат харилцааны олон талт, идэвхтэй үйл ажиллагаа, арга хэрэгслүүд, мөн хоёр талт харилцааны түүхэн уламжлалаар хөрш улсуудын ашиг сонирхлыг амжилттай тэнцвэржүүлж, “Гуравдагч хөрш”-ийн бодлогоо тууштай хэрэгжүүлж байна.

Үндэсний аюулгүй байдалд салбар дамнасан бодлогын зохицуулалт шаардлагатай хэдий ч улс орны батлан хамгаалах, хил хамгаалал, хууль сахиулах салбарын хөгжил, мэдээллийн аюулгүй байдал болон хүн, нийгмийн амар тайван байдлыг хангах асуудлыг тусгайлан авч үзэж хөгжлийн бодлогодоо тусгаж, хэрэгжүүлэх нь чухал юм.

Тиймээс “Амар тайван, аюулгүй нийгэм” зорилгын хүрээнд Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгохын зэрэгцээ хууль, шударга ёсны тогтолцоог бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн, амьдралын таатай байдлын үзүүлэлтүүдийг дээшлүүлж, нийгмийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлсэн нь хүн төвтэй хөгжлийн үзэл баримтлалын тулгуур зарчмын илэрхийлэл юм.



АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

ШИНЭ СОРИЛТЫН ӨМНӨХ МОНГОЛ

Их Монгол Улсын тогтоосон тал нутгийн дэг журам, андгайт ёсны доор эвлэж, Ази, Европын олон улс, үндэстнүүд аюул эрсдэлгүй бүрэн хамгаалагдсан замаар худалдаа арилжаагаа явуулж, өртөө-улааны логистикоор түргэн шуурхай харилцаж байв. Үндэс угсаа, хэл, шашин шүтлэг, соёл заншлын ялгаатай байдлаас үл хамааран хүмүүс Монголын эзэнт гүрэн, угсаат хөвгүүдийн нутгаар чөлөөтэй зорчиж, өөр хоорондоо ур чадвар, эрдэм боловсрол, гүн ухаан, технологи болон хөрөнгө санхүүгээ солилцож байсан түүхтэй билээ.

Дэлхийн өнцөг булан бүрд болж буй зэвсэгт халдлага, мөргөлдөөн, үймээн самуун, амь, амьдралаа дэнчинд тавьж, эх орон, элгэн саднаа орхиж буй дүрвэгсэд, байгаль, цаг уурын өөрчлөлт, хоол хүнсний хомсдол, хувирал болон дижитал шилжилт энэ бүхэн хүн төрөлхтний амар амгалангийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. Энэхүү аюулгүй байдлын төлөв, өөрчлөлтөөс үүдэн үндэстэн дамнасан гэмт хэрэг, дэлхийг хэрсэн цахим сүлжээ, халдварт өвчин, дүрвэгсдийн их нүүдэл, шашны хэт үзэлтнүүдтэй холбоотой уламжлалт бус аюул, занал өсөх хандлага ажиглагдаж, түүнтэй аливаа улс орон дангаар бус хамтран тэмцэж байж үр дүнд хүрэх нь нэгэнт тодорхой болоод байна.

Хөгжлийн хандлага, олон улсын харилцааны уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарч буй шинэ аюул заналууд дэлхийн дэг журам, хүчний тэнцвэр, ялангуяа эдийн засгаар давамгайллагч гүрнүүдийн эрэмбэ, дарааллыг хөдөлгөж буйтай холбоотойгоор үүсэн гарч байна. Олон улсын харилцааны неореалист сургуулийг үндэслэгчдийн нэг Кеннед Нил Вэльц (Kenneth Neal Walts) хүчний тэнцвэрийн онолдоо дэлхий дахины системийн анархи бүтцийн харилцан үйлчлэл нь эрх баригчид, эсвэл дарангуйлагчийн байр сууринаас гүн гүнзгий хамааралтай гэж үзсэн. Олон улсын анархизм бол нийгмийн шинжлэх ухааны ухагдахуун шиг эмх

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ



замбараагүй байдлыг бус улс орнуудын тусгаар тогтносон, бие даасан буюу удирдлагагүй байдлыг илэрхийлдэг ойлголт бөгөөд ийм бүтэц бүхий олон улсын харилцааны орчинд хүчний тэнцвэрээ хадгалах хамгаалалтын реализм, энэхүү тэнцвэрийг өөрчилж өөрт ашигтайгаар эргүүлэхийг эрмэлзэх довтолгооны неореалист хандлагууд илрэн гардаг байна.


Хүчний тэнцвэрийн онолын чухал хэсэг бол улс хоорондын үл итгэлцэл, ашиг сонирхлын мөнхийн зөрчилдөөн юм. Эдгээрээс хүчний тэнцвэр алдагдах нөхцөл үүсэж, хүсэшгүй үр дагаврыг дагуулах нь ч бий.

Батлан хамгаалах хүч, нөөц, эдийн засгийн хөгжил, улс төр, нийгмийн байгууллын хүчирхэг тогтолцоо бүхий хоёр том гүрний дунд орших манай улс худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнүүлээд зогсохгүй улс төр, нийгмийн ардчилал, ил тод, нээлттэй байдлаа хадгалах нь чухал юм. Монгол Улсын ил тод, нээлттэй, иргэний нийгмийн төлөвшил нь улс орныхоо аюулгүй байдлыг хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болдог. Ингэснээр гадаад бодлогын итгэлцлийг бэхжүүлж, улмаар аюулгүй байдлыг улам бүр баталгаажуулж буй юм.

Пакс монголика

"Монголын энх тайван" гэсэн утгатай Pax Mongolia нь XIII-XIV зууны Монголын эзэнт гүрний үед Евразийн тогтвортой амар тайван байдлыг илэрхийлдэг.

Зураг 1. Дэлхийн энх тайвны үзүүлэлт



Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.

Хүчний тэнцвэрийн онолын хүрээг өргөжүүлж, аюул заналхийллийн тэнцвэрийн онолыг боловсруулсан эрдэмтэн Стивэн Волт (Stephen Walt) олон улсын эвсэл, холбоод болон бусад хамтын ажиллагааны арга хэлбэрүүд, тэдгээрт нөлөөлж буй шалтгаан, хүчин зүйлсийг шинээр тодорхойлж, тэнцвэржүүлэх механизмуудын зүй тогтлыг өөр өнцгөөр харснаараа дэвшилттэй байлаа. Тэрээр бүс нутгийн буюу олон улсын хэмжээний эвсэл, бүлгүүд хүчний тэнцвэрийг хангах гэхээсээ илүүтэй болзошгүй аюул, эрсдэлийг сөрөх, урьдчилан сэргийлэх ашиг сонирхлын үүднээс бий болж байна гэж үзсэн юм. Олон улсын харилцааны цөөн туйлт системийн үед эвсэлд нэгдэх үйл явц тухайн хүчирхэг гүрнийг дагах, орох шинжтэй байдаг бол олон туйлт харилцааны тогтолцоонд энэ нь зүй ёсны үзэгдэл юм. Тодорхой нэг улс орон, бүс нутгийн хүрээнээс хальсан глобал шинжтэй нэн шинэ аюул занал нүүрлэн буй эдүгээ цагт тэдгээрийн сөрөг нөлөөг бууруулах, арилгах талаар хамтран ажиллахдаа үндэсний болон улсын аюулгүй байдлыг хангах асуудлаа ач холбогдлын тэргүүн эрэмбэд тавих нь зүй ёсны хэрэг.

“Жинхэнэ аюулгүй байдал гэдэг зөвхөн цэргийн заналхийллээс хамгаалагдсан байхыг хэлээд зогсохгүй, тухайн улс, ард түмэнд тулгарсан улс төр, эдийн засаг, нийгмийн хамгааллын олон талт эрсдэлийг зохицуулах явдлыг хэлнэ” хэмээн Оксфордын эрдэмтэд үзэж (Helga Haftendorn, Robert O. Keohane, Celeste A. Wallander) “Imperfect Unions: Security Institutions over Time and Space” бичсэн байна. Ингэж аюулгүй байдлын асуудлыг гадаад төдийгүй дотоод харилцааны орчинд, улс төр, эдийн

Зураг 2. Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг

Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг



Оршин тогтнохуйн
аюулгүй байдал



Эдийн засгийн
аюулгүй байдал



Дотоод
аюулгүй байдал



Хүний
аюулгүй байдал



Орчны
аюулгүй байдал



Мэдээллийн
аюулгүй байдал




Зураг 3. Улс орнуудын аюулгүй байдлын үзүүлэлт ба Монгол

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ 2022



Монгол Улс

42 байр
163 орноос



Эх сурвалж: Vision of Humanity, 2022

засаг, нийгэм, байгаль орчин болон хүний амьдрах, хөгжих бүхий л орчин нөхцөлийн харилцаа хамааралд нь авч үзэх хандлага өнгөрсөн зууны сүүлээс эхэлсэн. Аюулгүй байдлын цогц онолд цэрэг, улс төрийн хүчин зүйлээс гадна нийгэм, эдийн засгийн, экологийн, мэдээллийн технологийн хүчин зүйлсийг нэгдмэл байдлаар авч үзэхийг зөвлөдөг.

Аюулгүй байдлын цогц ойлголтод, нэгдүгээрт, хүн төрөлхтнийг бүхэлд нь хамарсан аюул заналыг сөрөн зогсох, улс төвтэй бүс, улс дамнасан олон улсын хүрээний буюу дэлхий нийтийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах асуудал, хоёрдугаарт, үндэсний аюулгүй байдлыг улс хоорондын харилцаагаар хангах буюу олон улсын болон бүсийн аюулгүй байдлын асуудал, гуравдугаарт, хувь хүнийг цэргийн болон цэргийн бус аливаа аюул занал, эрсдэл, айдсаас хамгаалах, чанартай амьдралын нөхцөлөөр хангах, хувь хүний иргэн, улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах тухай шинэ үзэл хандлага багтаж байна. Гэхдээ эдгээрийн дотроос хамгийн нийтлэг хандлага нь хүний аюулгүй байдлыг хангахад төвлөрч байна.

Олон улсын “Vision of humanity” байгууллагын судалгаагаар 2022 оны байдлаар энх тайван, аюулгүй байдлын үзүүлэлтээр манай улс 163 орноос 42 дугаар байранд эрэмбэлэгдэж байна. Террорист ажиллагаа, дүрвэгсэд, дотоод гадаад зөрчил гэхээр зүйл үгүй, эдгээрт харгалзах хамгийн бага буюу нэг оноог тогтмол авч ирсэн нь “бид илүү амар тайван нөхцөлд амьдарч байна” хэмээн үнэлэгдэх үндэс болж байна. Гэвч дотоодод, 2021 оны эхний хагас жилийн статистик мэдээллээс харвал, сүүлийн гурван жилд гэмт хэргийн тоо буурсан ч авлига, мөнгө угаах,

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн.

Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, нийгмийн тогтвортой байдлыг хангасан ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.

хүн худалдаалах болон цахим гэмт хэрэг 30-43 хувиар өсжээ. Мөн энэ хугацаанд мансууруулах болон сэтгэгдэд нөлөөлөх бодисын хэрэглээтэй холбоотой гэмт хэрэг 830 бүртгэгдсэн ба төрлийн гэмт хэрэгт холбогдогчдын 68 хувь нь 18-30 насны залуучууд байгааг хайхрахгүй орхиж хэрхэвч болохгүй.

Улсын аюулгүй байдлыг төрөөс салгаж ойлгох аргагүй. Иймд төр легитимт чанараа алдаж, түүнд итгэх иргэдийн итгэл алдрах байдал газар авбал ноцтой үр дагаварт хүргэнэ. Дотоодын дайн, зөрчлийн уг сурвалж ч ийм шалтгаантай байх нь олонтаа. Сүүлийн үед монголчуудын төрдөө итгэх итгэл буурч байгаагийн суурь шалтгаан нь шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл явцад шударга, зарчимч байдал алдагдсан явдал бөгөөд улмаар төрийн үйлчилгээ, зохицуулалт иргэн хүнд шууд хүрэх үндсэн логистик гажуудаж, элдэв нугалаа завхралын нөлөөгөөр эерэг шийдвэр сөрөг ойлголт болж очих тохиолдол ч байна. Энэ нь ард иргэдийн амьдралын идэвх, ирээдүйд итгэх итгэлийг алдагдуулж, ноцтой үр дагаварт хүргэхийг үгүйсгэхгүй. Хаана ирээдүй тодорхойгүй байна, тэнд эрсдэл оршин байдаг. Эрсдэл бол аюул ба эмзэг байдал хоёрын харилцан үйлчлэлийн үр дүн юм. Нийгмийн, иргэдийн эмзэг байдал нь тэднийг аюулын нөлөөлөлд өртөх байдлыг ихэсгэдэг гол хүчин зүйл болдог.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, “Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн” гэж заагаад, “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална” гэж тусгасан.

Дэлхий дахиныг хамарсан коронавируст халдварын цар тахал улс орнуудын эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна. Хөрш орнуудтай худалдааны харилцааны гол суваг болох хилийн боомтууд хаагдахад Монгол Улсад эдийн засгийн суурь үнэ огцом нэмэгдэж, үйлдвэрлэл доголдон, зарим хүнсний хангамж буурч байна. Энэ нь эдийн засгийн хувьд хөрш орнуудаас хэт хамааралтай байгааг харуулж байна. Эдийн засгийн бие даасан байдал хангагдаагүйн зэрэгцээ байгалийн гамшгийн давтамж нэмэгдсэн, цаг уурын өөрчлөлт дулаарлаас шалтгаалсан орчны доройтол иргэдийн уламжлалт аж ахуй, амьжиргаанд хүчтэй нөлөөлсөн, хүний эрх, эрх чөлөөг хангах эрүүл, аюулгүй амьдрах орчин бүрэн



хангагдаагүй, баян, ядуугийн зааг ялгаа хэт нэмэгдсэн, дундаж давхаргын цар хүрээ нимгэрсэн зэрэг олон эрсдэл монголчуудын аюулгүй байдал, амар тайван амьдралд сөргөөр нөлөөлж байна. Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын зорилго, зориултуудыг урт хугацааны хөгжлийн бодлогодоо тусгасан нь цаг үеийн шаардлагаар зайлшгүй шийдвэрлэх ёстой алхам болохыг дээр дурдсан хүчин зүйлс нотолж байна.


Аливаа нийгэм амар тайван, аюулгүй байх нь тус улсын иргэд, оршин суугчдаар тогтохгүй, тухайн орныг зорих жуулчид, бизнес эрхлэгчдийн хувьд шийдвэр гаргахад нөлөөлөхүйц, чухал үзүүлэлт болдог. Монгол Улс хоёр том гүрний дунд, хөршүүдтэйгээ элдэв маргаангүй, хилийн зөрчилгүй хэдий ч цаг үеийн болон геополитикийн шинэ аюул, сорилт дэлхий дахинд өрнөж байна. Улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах чиг үүрэг хэвээр байгаа хэдий ч дээрх аюул заналын шинэ орчноос үүдэлтэй цэргийн ажиллагаа явуулах уламжлалт ойлголт, арга хэлбэр, үүрэг ч өөрчлөгдөж байна. Иймд бид хөгжлийн зорилтоо тодорхойлоход дэлхийн эрсдэлийн үзүүлэлт, олон улсад үүсэж буй гадаад нөхцөл байдал, дотоод нөөц, давуу болон сул талаа нарийн тооцож үзэх шаардлага тулгарч байна.

“Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн.”

Зураг 4. Дэлхийн эрсдэлийн үзүүлэлт

ДЭЛХИЙН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2022

ОЙРЫН 5-10 ЖИЛД



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум, 2022

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

ЗЭВСЭГТ ХҮЧИН

ЗОРИЛТ 7.1 Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг зэвсэгт хүчнийг бэхжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо бэхжих үе



Зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах явдал мөн.

Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлэх энэхүү зорилтын хүрээнд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжлийн хэтийн төлөв, цаашдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан Зэвсэгт хүчний тухай хуульд 2020 онд нэмэлт, өөрчлөлт орж батлагдсан. Ингэснээр Монгол Улсын Зэвсэгт хүчин түүхэн хөгжлийнхөө явцад урьд байгаагүйгээр өргөжин хөгжих эрх зүйн зохицуулалт бий болгож, Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, Агаарын цэрэг, Барилга-инженерийн цэрэг, Кибер аюулгүй байдлын болон Тусгай хүчний цэргээс бүрдэхээр хуульчлагдсан.

Мэргэжлийн, өндөр чадамжтай зэвсэгт хүчнийг бүрдүүлэх, бэхжүүлэхийн нэг гол хүчин зүйл нь цэргийн сургалт, бэлтгэл, байнгын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх ололтуудыг нэвтрүүлж, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх явдал юм.

Энэхүү бодит хэрэгцээ, шаардлагыг үндэслэн батлан хамгаалах салбарын эрдэмтэн, судлаачид хөгжингүй орнуудад суралцаж, орчин үеийн цэргийн техник, технологийн суурь мэдлэгийг эзэмшсэн алба хаагчдаа түшиглэн орчин үеийн технологийн ололт, шийдлийг тодорхой хэмжээнд нутагшуулан, тусгай зориулалтын цэргийн авто техник, нисгэгчгүй нисэх төхөөрөмж,



Зураг 5. Зэвсэгт хүчний бүтэц, бүрэлдэхүүн



радио электрон хэрэгслийн эхний загваруудыг бүтээж, зарим техникийг хүлээн аваад байна.

Цаашид дэвшилтэт технологийг батлан хамгаалах салбарт нэвтрүүлэх судалгаа хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлж, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах зорилт тавьсан.

Олон улсын байдал тогтворгүй болох хандлага ажиглагдаж, эдийн засгийн харилцан нөхсөн, даяаршсан үйл явц саарч буй өнөө үед улс орнууд шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллаж, аливаа нээлт, шинэчлэлийг энхийн зорилгод ашиглахын зэрэгцээ эдгээрийн давуу талыг аюулгүй байдал, батлан хамгаалах салбартаа бий болгох, өрсөлдөгч талуудаас технологи, туршилт, үйлдвэрлэлийн нууцыг хамгаалахад онцгой анхаарах болжээ. Сүүлийн 20-оод жилд болсон, мөн энэ цаг үед болж байгаа орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлага, сургамжаас харахад эдүгээгийн улс хоорондын тэмцэл, сөргөлдөөнд цэргийн ба цэргийн бус хүч хэрэгслийг хослуулсан операцууд түгээмэл болж байна. Ийм операцын үр дүн нь улс төрийн, эдийн засгийн, мэдээллийн зэрэг цэргийн бус хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай болоод байна.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь цэргийн жинхэнэ алба хаагч, зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарт ажиллаж байгаа иргэнээс бүрдэнэ. Зэвсэгт хүчний улс төрийн дээд удирдлагыг УИХ, төрийн захиргааны удирдлагыг Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч буюу Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хэрэгжүүлдэг.

АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ НИЙГЭМ

**ЗЭВСЭГТ
ХҮЧИН**

Иймд Монгол Улс цаашид батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчиндээ хиймэл оюун ухаан, их өгөгдөл, юмсын интернэт, үүлэн тооцоолол, 3D болон тоон технологид суурилсан ухаалаг үйлдвэрлэл, үйлчилгээ, генийн инженерчлэл, кибер физик систем зэргийг өргөн ашиглах шаардлага зүй ёсоор урган гарч байна.


Цэргийн хүчин чадлын олон улсын үзүүлэлтээр манай улс 2022 онд 140 орноос 102 дугаарт эрэмбэлэгджээ. Таван жилийн өмнө буюу 2016 онд 126 орныг багтаасан уг жагсаалтад манай улс 85 дугаар байр эзэлж байв.

Монгол Улс өргөн уудам нутаг дэвсгэртэй, хоёр их гүрний дунд оршдог, хүн ам цөөнтэй, цэрэг-эдийн засгийн чадавх зэргээс шалтгаалан орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцоог сонгосон.

Орон нутгийн хамгаалалт нь “Батлан хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн орон нутгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой, бие даасан хөгжлийг дэмжих, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга

Зураг 6. Дэлхийн орнуудын зэвсэгт хүчний хүчин чадлын эрэмбэ

ДЭЛХИЙН ОРНУУДЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХҮЧИН ЧАДЛЫН ЭРЭМБЭ (2021)



Эх сурвалж: GlobalFirepower.com, 2022



хэмжээний цогц” бөгөөд иргэдийн эх орноо хамгаалах, гамшиг, ослын үед авран хамгаалах, хор уршгийг арилгах зохион байгуулалттай олон чухал “иргэний үүргүүд”-ийг чадварлаг биелүүлэх бэлтгэл болж байна.

Нөгөө талаар хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн баталгаагаа хангах давуу эрх олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгож, цэргийн албаны бахархлыг сэргээх учиртай.

Цэргийн албаны тухай хуулиар иргэний цэргийн алба хаах нэгэн хэлбэрийг бий болгож, 2014 онд эхлүүлсэн “Оюутан цэрэг” цэргийн мэргэжил олгох сургалтад өдгөө их, дээд сургуулийн 5,500 орчим оюутан залуучууд хамрагдаад байна. Ингэснээр тэдэнд эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, эр зориг, тэсвэр хатуужил олгох сургалтыг тодорхой хугацаанд олгож, цэргийн бага мэргэжилтэн, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлж байна.

Салбарын зүгээс хугацаат цэргийн албаас гадна 2010 онд цэргийн анхан шатны боловсрол олгох “Тэмүжин өрлөг” дунд сургуулийг байгуулсан нь Зэвсэгт хүчний залуу халааг бэлтгэж, ирээдүйгээ эх оронч сэтгэлтэй болгон хүмүүжүүлэх ажлын эхлэл болсон. Засгийн газраас 2019 оны тавдугаар сард Таван толгой-



Орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээ нь тайван цагт орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, уламжлалт аюулаас урьдчилан сэргийлэх, уламжлалт бус аюулаас хамгаалах, онц болон дайны байдлын үед орон нутгаа хамгаалах замаар улсыг батлан хамгаалахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.



Монгол Улсын зэвсэгт хүчин нь улсыг цэргийн хүч, хэрэгслээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага мөн.

Зүүнбаян чиглэлийн төмөр замын ажилд барилгын цэргийг оролцуулах шийдвэр гаргасан нь улс орны хэмжээний томоохон бүтээн байгуулалтыг цэрэг армийн оролцоотой хийж гүйцэтгэх шинэ санаачилга болсон юм. Социализмын үеийн 70 жилийн хугацаанд Монгол Улс даяар өрнөсөн бүтээн байгуулалтад ч мөн адил цэргүүд, тэр дундаа барилгын болон инженерийн цэргийн албан хаагчид ихээхэн хувь нэмэр оруулсан билээ.

Зэвсэгт хүчний бүтцэд бүтээн байгуулалтын дэмжлэгийн газар нэртэйгээр байгуулагдаж байсан Барилга-инженерийн цэргийн удирдах газар өдгөө барилга, зам гүүр, төмөр замын бүтээн байгуулалт, экологийн сэргээн босголтын үйл ажиллагааг гардан хэрэгжүүлэх мэргэжлийн чадварлаг бие бүрэлдэхүүнтэй, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий техник, тоног, төхөөрөмжөөр хангагдсан, зохион байгуулалттай хүч хэрэгслээр богино хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх чадавх бүхий мэргэжлийн үндсэн болон хээрийн анги, салбаруудаас бүрдэж, үндэсний бүтээн байгуулалтад манлайлан оролцож байна. Тухайлбал, Барилга-инженерийн цэргийн ангиуд Дорноговь



Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.



аймгийн Алтанширээ сум дахь “Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг Сайншанд хоттой холбох 17.5 км хүнд даацын авто зам, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн хотхоны 5 блок барилга, “Дорнод аймгийн Халх гол суманд “Шинэ сум” төсөл”, “Таван толгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр зам”-ын бүтээн байгуулалтын ажил зэрэг улс орныг хөгжүүлэх стратегийн томоохон бүтээн байгуулалтын ажилд голлох үүрэгтэй оролцлоо.

“Зүүнбаян-Ханги” чиглэлийн 223.6 км төмөр замын байгууламжийг байгуулах төслийн ажлыг эхлүүлж, амжилттай гүйцэтгэж байна. Цаашид барилга-инженерийн ангиудыг төмөр зам, авто зам, нефтийн үйлдвэр, цахилгаан станцын барилга зэрэг улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтын ажилд үргэлжлүүлэн оролцуулахын зэрэгцээ Зэвсэгт хүчний алба хаагчдыг цөлжилтийн эсрэг тэмцэх, экологийн үйлсэд оролцуулах бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд батлан хамгаалах салбар нэгдэж, 2030 он гэхэд 22 сая гаруй модыг тарьж ургуулахаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Улс орны хэмжээний томоохон бүтээн байгуулалтыг цэрэг армийн оролцоотой хийж гүйцэтгэж байсан уламжлал сүүлийн жилүүдэд төмөр замын бүтээн байгуулалтад идэвхтэй оролцож байгаагаар хадгалагдаж байна.



Зураг 7. Зэвсэгт хүчин нь тайван цагт дараахь үүрэг хүлээнэ.



Эх сурвалж: Монгол Улсын Их Хурал, 2016

Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүнийг сургах, чадавхыг нэмэгдүүлэх, батлан хамгаалах салбарын алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилго бүхий Зэвсэгт хүчний хөгжлийн сантай байна.

Зэвсэгт хүчний хөгжлийн санхүүжилтэд найман төрлийн эх үүсвэрээр хөрөнгө бүрдүүлэх зохицуулалттай ч зөвхөн энхийг дэмжих ажиллагааны нөхөн төлбөрийг л авдаг байсан. Тусгай сангийн тухай хуулиар зохицуулагддаг байсан хөгжлийн санхүүжилт нь Зэвсэгт хүчний тухай хуулиар Зэвсэгт хүчин өөрийн орлого, зарлагаа удирдах боломж бүрдсэн.

Хөрөнгө нэмэгдэж гэмээнэ Зэвсэгт хүчний хөгжилд бодитой үр дүн үзүүлэх ач холбогдолтой. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг бүтээн байгуулалтын ажилд татан оролцуулснаар алба хаагчдын цалин, орлого нэмэгдэхийн зэрэгцээ Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого нэмэгдэх юм.



БҮХ ЦЭРГИЙН ХАР СҮЛД

Бүх цэргийн их хар сүлд гэдэг бол туурга тусгаар Монгол Улсын Төр, цэргийн сүр хүчний бэлгэдэл бидний сүсэглэн дээдлэх оройн дээд шүтээн юм. Бүх цэргийн хар сүлдийг цэнгүүлэх тайлга, цагаалах тайлга гэж байдаг. Цэнгүүлэх тайлгыг хоёр жилд нэг удаа, зуны дунд сард туг, сүлдний зохилдлоготой өдөр хийдэг, харин цагаалах тайлгыг жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн гурванд өргөөнд нь зохион байгуулдаг юм. Хар сүлдийг цэнгүүлэх тайлгыг үйлдэх зан үйл байна. Бүх цэргийн хар сүлдний их сүлдэчийн командаар Бүх цэргийн Их хар сүлдийг өмнө, дорно, өрнө, умрын элч сүлдийн хамт тусгайлан зассан суудалд залахад цэргийн албан хаагчид ёслон хүндэтгэнэ. Их сүлдэч зул, арц хүж асаан сүлдэндээ гурвантаа мөргөхөд төрийн хожин “Бүх цэргийн Их хар сүлдний тайлга эхэл, сүлдэнд ниндар өргө, зул өргө, утлага өргө, идээ өргө, сархад өргө” командуудыг өгдөг. Дараа нь “Бүх цэргийн Их хар сүлдэнд өчил өч” командаар их сүлдэч өчил уншихад тайлгад оролцогчид малтайгаа авч баруун өвдөг дээрээ сөхөрч суун Их хар сүлдэндээ хүндэтгэл үзүүлнэ. Өчил өчиж байх үеэр харваач тайлгын их нумаар “Өрсөх дайсан болгоныг өвдөг сөгдүүлэн номхотгож байна” хэмээн шившиж, гурван сум тавина. Энэ нь өвөг дээдсээс уламжилж ирсэн өв соёлоо хадгалан үлдэж, тээж яваа нэг хэлбэр юм.

Монгол Улсын зэвсэгт хүчин нь улсыг цэргийн хүч, хэрэгслээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага мөн.



ЭНХИЙН ҮЙЛСИЙГ ТҮҮЧЭЭЛЖ БУЙ МОНГОЛ ЦЭРГИЙН БАХАРХАЛ

1948 онд НҮБ-ын Аюулгүйн зөвлөл цэргийн ажиглагчдыг Ойрхи Дорнод руу Израил болон Арабын хөрш орнуудын хооронд байгуулсан дайныг зогсоох хэлэлцээрт хяналт тавиулахаар дайчилснаар энхийг сахиулах ажиллагаа эхэлсэн байна. Үүнээс хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд 1.0 сая гаруй алба хаагч НҮБ-ын далбаан дор 70 гаруй энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэжээ. Манай улс тус ажиллагаанд оролцсоны 20 жилийн ойгоо угтаж байна. Энэ хугацаанд давхардсан тоогоор 20,300 гаруй цэргийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байна.

Тэртээх 2002 оны наймдугаар сард Ч.Ерөөлцэнгэл, Р.Даваадорж нар Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад НҮБ-ын энхийг сахиулах MONUC ажиллагаанд цэргийн ажиглагчаар үүрэг гүйцэтгэхээр томилогдсоноор Монгол цэргийн энхийн үйлсийн түүхэн замналыг эхэлсэн юм. Өнөөдрийн байдлаар НҮБ-ын мандаттай болон олон улсын 18 ажиллагаанд 77 цэргийн баг, 400 гаруй штабын ажилтан, цэргийн ажиглагч офицерууд үүргээ амжилттай гүйцэтгээд байна.

Өдгөө Өмнөд Судан улс, Абей муж, Баруун Сахаар, БНАКонго, Йемен зэрэг таван улсын нутаг дэвсгэрт явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд штабын офицер,

Олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, зэвсэгт мөргөлдөөнийг таслан зогсоох, түүний хор уршгийг арилгах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын дор явагдаж байгаа олон үндэстний үйл ажиллагааг "Энхийг дэмжих ажиллагаа" гэдэг.





ахлагч-15, ажиглагч офицер-14, Өмнөд Судан Улсад “UNMISS” ажиллагаанд цэргийн багийн-849, нийт 878 цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй биелүүлж байгаа бөгөөд Монгол Улс нь НҮБ-ын цэрэг хандивлагч орнуудаас эхний 24-т жагсаж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багуудыг үүрэг гүйцэтгэх хугацаанд 2006 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Кофи Анан, 2010 онд Бан Ги Мун нар цэргийн багт айлчлах үедээ “Монгол цэргүүдийн эр зориг, тэсвэр хатуужил, мэргэжлийн ур чадвар”-ыг өндрөөр үнэлсэн болно. Түүнчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багууд Тусгай шүүхийн харуул, хамгаалалтын үүргээ амжилттай дуусгавар болсны дараахан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гаргасан тогтоолд “Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багт гүн талархал илэрхийлье” хэмээн цохон тэмдэглэсэн нь манай Зэвсэгт хүчний хувьд бахархал байлаа.

Цаашид НҮБ-ын энхийн ажиллагаанд Монгол Улсын оролцоог нэмэгдүүлэхийн тулд НҮБ-ын бэлэн байдлын системд Монгол Улсаас мотобуудлагын батальон нэг, хоёрдугаар шатны эмнэлэг нэг, инженерийн рот нэг, тусгай хүчний рот нэгийг тус тус шинээр бүртгүүлж бэлэн байдлын түвшин ахиулах үзлэг шинжээчийн бүлгийн шалгалтад тэнцэж НҮБ-ын энхийн ажиллагаанд цэрэг хандивлах бэлтгэлийг ханган ажиллаж байна



Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагааны газар оронд болон олон улсын цэргийн хүчний командлалын өндөр албан тушаалд ажиллах хүчний нөөцийг бэлтгэх, үүрэг гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.





2022 оны "Хааны эрэлд" олон улсын хээрийн сургуульд 15 улсын 1,000 орчим цэргийн албан хаагч оролцжээ.



ОРОН ОРНЫ ДАЙЧИД "ХААНЫ ЭРЭЛД"

Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг дэмжих үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 2003 оноос эхлэн "Хааны эрэлд" сургалт, дадлагыг хоёр талын хэлбэрээр явуулжээ. 2006 оноос үүнийг бүс нутгийн орнуудын энхийг сахиулагчдыг хамруулан оролцуулсан олон үндэстний энхийг дэмжих ажиллагааны сургалт болгон өргөжүүлсэн юм. Улмаар "Хааны эрэлд" нь энэ төрлийн сургалт, дадлагын туршлагыг хуримтлуулах, бусад орны энхийг сахиулагчдаас суралцах өргөн боломжийг олгосон, бүс нутгийн хэмжээний томоохон сургуулиудын нэг болжээ.

2006 онд 16 орны 500 гаруй цэргийн алба хаагч оролцсон бол 2007, 2008, 2009, 2011 онд оролцогсдын тоо 1,000 гарснаар Ази, Номхон далайн улс орнуудын энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр хэрэгждэг таван том арга хэмжээний нэг болсон юм.

"Хааны эрэлд" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт, дадлагын хүрээнд Команд штабын сургууль, Тактикийн хээрийн сургалт дадлага, Хүмүүнлэгийн тусламжийн ажиллагаа, Эмнэлгийн хөдөлгөөнт бүлгийн ажиллагаанууд гэсэн хэд хэдэн төрлийн сургалтын арга хэмжээ зохион байгуулагдаж байна. Тус сургалтаар зөвхөн энхийг сахиулагчдыг сургаж дадлагажуулахаас гадна манай улсын иргэдэд хүмүүнлэгийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг уламжлалтай Эмнэлгийн хөдөлгөөнт бүлгийн ажиллагааг 2004 оноос эхлэн жил бүр зохион байгуулсан.





“Хааны эрэлд” олон үндэстний энхийг дэмжих ажиллагааны сургалтад оролцсон Монгол Улсын Зэвсэгт хүчний олон арван алба хаагч Ирак, Афганистан, Сьерра-Леон, Судан болон Африкийн зарим орнуудад энхийг дэмжих ажиллагаанд амжилттай оролцсоор байгаа юм. “Хааны эрэлд” сургалт, дадлагад гадаадын болон Монголын нийт 5,000 гаруй цэргийн алба хаагч оролцоод байна.

Түүнчлэн “Хааны эрэлд” олон улсын цэргийн сургуулилалтыг НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагааны зорилго, зорилттой уялдуулснаар утга агуулга нь өргөжиж байна. Тухайлбал, АНУ-ын санаачилсан Даян дэлхийн энх тайвны санаачилга (GPOI)-тай хамтран ажиллах болж, цар хүрээ нь тэлжээ. Даян дэлхийн энх тайвны санаачилга нь энхийг сахиулах ур чадварыг сургах, тогтвортой байлгахад түнш орнуудын чадавхыг нэмэгдүүлэх замаар НҮБ болон бүс нутгийн энхийг дэмжих ажиллагааг үр дүнтэй явуулах олон улсын чадавхыг нэмэгдүүлэх зорилготой хөтөлбөр юм. Энхийг сахиулах хүчинд байршуулах боломжтой цэргийг чадавхжуулах, байгуулагдсан хүчний нэгжийн тоог нэмэгдүүлэх, цэргийн ангиудыг бэлтгэх, техник хангамжаар хангах, байршуулах ажлыг хөнгөвчлөх зорилготой. Хөтөлбөрийн эхний таван жилийн үндсэн зорилтууд нь 75,000 энхийг сахиулагчийг сургах, энхийг сахиулах үйл ажиллагаа явуулах бүс нутгийн чадавхыг бэхжүүлэх явдал байв. Дараагийн үе шатанд уугуул иргэдийн энхийг сахиулах ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд түнш орнуудын хүчин чармайлтад туслахад шилжсэн. Даян дэлхийн энх тайвны санаачилгын “Сургагч багш бэлтгэх” сургалтыг “Хааны эрэлд” сургуулилалтын хүрээнд зохион байгуулах болсон бөгөөд 2020 оны байдлаар 40 гаруй зааварлагч багш уг сургалтаас бэлтгэгдэж гарсан нь Монголын энхийг сахиулагчдыг НҮБ-ын үйл хэрэгт манлайлан оролцох бэлтгэл болж буй юм.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн нь сайн дурын үндсэн дээр сонгогдож, уг ажиллагааны өмнөх тусгай сургалтад хамрагдсан байна.

ЭХ ОРНОО ХАМГААЛАХ ЭГНЭШГҮЙ НЭР ХҮНД



Эх орноо хамгаалах нь монгол хүн бүхний үндсэн үүрэг бөгөөд энэ үүргээ биелүүлэх хамгийн бодит хэлбэр нь цэргийн алба хаах явдал юм. Цэргийн алба хааж, эх орноо батлан хамгаалах үүргээ гүйцэтгэх нь нэр төрийн хэрэг байх бүхий л зохицуулалтыг Монгол Улс хуульчлан баталгаажуулж өгсөн. Бие бялдрын хөгжил, эрүүл мэнд, нас, боловсролын шаардлага хангасан, хугацаат цэргийн албаа хаасан иргэд цэргийн гэрээт албыг байлдагч, түрүүчийн болон ахлагч, офицерын гэсэн төрлөөр үргэлжлүүлэн хаах боломжтой. Цэргийн алба хүнд боломж, сонголт өгөхийн зэрэгцээ эх орноо хайрлах хайр, хүн хүндээ сайн сайхнаар хандах чин дотно сэтгэлийг төрүүлдэг. Амьдралын үнэ цэн, утга учрыг ухаарч, тэсвэр хатуужил суун, зорилго тэмүүллээ тодорхойлж, ирээдүйдээ итгэх, эр зориг, чин шударгууг сургахад тусална. Тийм ч учраас цэл залуу охид, хөвгүүд цэргийн алба хаахыг эрхэмд үзэж, биелүүлсэн үүрэг, өөртөө бий болгосон үнэт зүйлсээр бахархах эрмэлзэлтэй болж байна.






ЦЭРГИЙН ТЕХНИКИЙГ ЦЭРГИЙН ИНЖЕНЕРҮҮД



Батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүрээнд батлан хамгаалах эрх ашигт нийцсэн цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн батлан хамгаалахын аж үйлдвэрийн суурийг тавих ажлыг амжилттай эхлүүлээд байна.

Нисгэгчгүй нисэх төхөөрөмж бүтээх төслийн баг орон зайн тандалт, агаарын тагнуулын зориулалт бүхий бага оврын “Ёл-1”, Ёл-2” загварыг бүтээсэн. Улмаар уг төслийн баг өнөөдрийн байдлаар өмнөх загваруудын судалгаа, туршилтын үр дүнд үндэслэн босоо хөөрөлтийн технологи бүхий нисэх зурвас шаардахгүй хөөрч, буух боломжтой “Хяналт-1” төхөөрөмжийг бүтээх төслийг хэрэгжүүлж байна.

Радио электроникийн хэрэгсэл зохион бүтээх судалгаа туршилтын ажлын хүрээнд богино долгионы дунд чадлын “Монрадио-1000” загварын радиостанцын анхны загварыг цэргийн холбооны инженер техникийн ажилтнууд амжилттай хийж гүйцэтгэсэн.



АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

ДАРХАН ХИЛ

ЗОРИЛТ 7.2 Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг ханган, хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг бэхжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Хил хамгаалалтын чадавхыг бэхжүүлж, гадаадын ижил төстэй байгууллага, хөрш орнуудын түвшинд хүргэх үе



Нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, олон улсын гэрээгээр тодорхойлон тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн эгц доош газрын хэвлийн хил оршино. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт дэглэм сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж буй үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ.

Монгол Улсын хилийн дархан байдал нь Үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг юм. Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хилийн аюулгүй байдал гэдэг. Монгол Улс Үндсэн хуульдаа “...нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” гэж заасан бөгөөд энэ нь нэгд, улсын хилийн халдашгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хоёрдугаарт, халдах тохиолдолд бат найдвартай хамгаалж, дархан байдлыг хадгалах цогц үйл ажиллагааг агуулж буй юм.

Хил хамгаалах байгууллага нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1933 оны 3 дугаар тогтоолоор Дотоодыг хамгаалах газрын харьяа Цэргийн ба Хязгаарын хэлтэс нэртэйгээр анх



байгуулагдаж байжээ. Тогтоолын дагуу Монгол Улсын хилийн аюулгүй байдал, гадаад, дотоод нөхцөл байдалд тулгуурлан мөн онд баруун ба өмнөд хязгаарыг хамгаалах үүрэг бүхий анхны хилийн отряд, комендатур, пункт (Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ)-ыг байгуулснаар орчин цагийн хил хамгаалах байгууллагын суурь тавигдсан гэж үздэг. Хил хамгаалах байгууллага нь улсын хилийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хамгаалалтыг зохион байгуулж, удирдах, олон улсын гэрээгээр хилийн талаар хүлээсэн Монгол Улсын үүргийг хэрэгжүүлж, дэглэмийг сахиулах, хилийн шугамыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх, зөрчлөөс урьдчилан сэргийлж, зөрчсөн тохиолдлыг таслан зогсоох, хуулийн дагуу шийдвэрлэх, боомтын аюулгүй байдлыг хангах, журам, дүрмийг сахиулах, шалган нэвтрүүлэх, хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, агаарыг хилийг сахин хамгаалах үндсэн үүрэгтэй. Эдүгээ Монгол Улсын нийт хилийн шугаман дээр өдөр бүр 5,000 хилчин байлдааны тушаалтайгаар үүрэг гүйцэтгэдэг.

Улсын хилийг хуулиар бататгах ардчилсан Үндсэн хуулийн зарчмын хүрээнд УИХ Хилийн тухай хуулийг удаа дараалан баталж, хоёр хөрш оронтойгоо хилээ хамтран шалгаж, шугамаа тогтоон, хилийн дэглэмийн гэрээнүүдийг байгуулсан нь Монгол

"Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна".

АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ
НИЙГЭМ

ДАРХАН ХИЛ

Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, халдашгүй байдлыг хамгаалах суурь, томоохон алхам болсон юм.


Хилийн тухай хуулийг 1993 онд анх баталсан бол 2016 онд шинэчлэн баталж, 2017 оноос мөрдөж байна. Манай улс 1962 онд БНХАУ-тай, хойд хөрш буюу тухайн үеийн ЗХУ-тай 1958 онд хилээ тогтоож, гэрээбайгуулан, гурван улсын хууль тогтоох байгууллагууд соёрхон баталснаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өнөөгийн хилийг зурсан түүхтэй. Эдгээр гэрээг бататган хянах томоохон алхам болох хилийн хамтарсан шалгалтыг ОХУ-тай нэг, БНХАУ-тай хоёр удаа хийгээд байна. Монгол, Оросын хилийн дэглэмийн тухай гэрээний дагуу талууд хамтарсан шалгалтыг 15-20 жил тутам зохион байгуулахаар тохиролцсон бөгөөд 2022 оноос эхлүүлж байна.

Он жил улирч, цаг үе өөрчлөгдөхийн хэрээр аливаад шинэчлэл үгүйлэгддэг. Үүний жишгээр хилийн өнөөгийн нөхцөл байдал ч Хүйтэн дайны үеийнхээс тэс өөр болж, аюулыг урьдчилан таамаглах боломжийг хумьж байна. Өнөөдөр Монгол Улс хоёр хөрштэйгөө хилийн асуудлаар хамгийн дээд түвшний харилцаатай байна.





Зураг 8. Газраар хамгийн урт хиллэдэг орнууд. (километрээр)



Эх сурвалж: Statista, 2022; XXЕГ 2022

Хилийн асуудал нь зөвхөн хөрш орнуудтай тогтоосон харилцаагаар хязгаарлагдах боломжгүй болох нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргээс сэргийлэх хориотой бараа таваар, эд зүйлсийг хилээр нэвтрүүлэхгүй, бас гаргахгүй байх үүргийг олон улсын өмнө хүлээх явдлаар илэрхийлэгдэж байна.

Хил, хил орчмын нутаг дэвсгэрт Монгол Улсын ашиг сонирхолд учруулж болзошгүй аюул, занал өнөө хэр хадгалагдсаар байгаа төдийгүй хэмжээ далайц, эрчим төрөл нь ихсэх хандлагатай байна. Ялангуяа газар нутгийн маргаан, зэргэлдээ улсад гарч байгаа цэргийн үйл ажиллагааны идэвхжил, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт явагдаж буй тагнуул, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, нийгэм, улс төрийн түгшүүртэй байдлын голомт, зэвсэгт мөргөлдөөн, дамын наймаа, гэмт хэргийн бүлэглэлүүдийн ажиллагаа, тэр дундаа олон улсын хар тамхины наймаа, терроризм үүсэх үндсийг судлан, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд таслан зогсоох талаар онцгойлон анхаарах шаардлагатай билээ. Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана.

Улсын хилийг газар дээр нь дараах зарчмыг баримтлан тогтооно:

- хуурай газарт тодорхой тэмдэгт, тогтвортой юмсыг хооронд нь холбосон шулуун шугамаар, эсхүл уул нурууны усны хагалбараар;
- гол, мөрөн, горхинд үндсэн урсгалын дундуур, нууранд нуурын эрэгт тулж ирсэн улсын хилийн шугамын хоёр үзүүрийг холбосон шулуун шугамаар;
- улсын хил дамнасан байгууламжид улсын хилийн шугам өнгөрч байгаагаар.



2019 онд Буйр нуурын
усан хил хамгаалалтын
хүчин чадлыг
нэмэгдүүлж, шинэ
аргачлалд шилжүүлжээ.



Зарим судлаачид аливаа улсын “хилийг дамнан нэвтрэн орж ирэх боломжтой гурван зүйл байна. Нэгдүгээрт, үзэл санаа, мэдээлэл, хоёрдугаарт, хүн, гуравт, эд зүйлс. Эдгээрийн дайж ирэх аюул, заналхийллийг ямар ч улсын хил бүрэн хянаж, тогтоон хамгаалах боломжгүй” гэж үздэг. ОХУ-ын судлаач С.А.Панарин 2016 онд нийтлүүлсэн өгүүлэлдээ хил хязгаарын аюулгүй байдалд тулгарч байгаа заналхийллийн өөдөөс хоёр хандлагаар ажиллаж болохыг өгүүлжээ. Тэрээр,

“Нэгдүгээрт, бараг төгс гэж хэлж болох улсын хилийн хамгаалалтыг бий болгох. Үүний тулд, улсын хилийг бүхий л шаардлагатай хянах, ажиглах, шалгах тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан, засаглалын хувьд аюулгүй байдлыг дээд зэргээр чухалчилдаг, хүчирхэг төр засагтай, авлига болон албан тушаалаа урвуулан ашиглах явдалд автагдаагүй өндөр мэргэжлийн хүний нөөц бүхий улсын хилийн хамгаалалттай болох.

Хоёрдугаарт, бодит байдал дээр ийм халдашгүй хилийг бий болгох боломж бараг байхгүй. Тэгэхээр аливаа нэг аюул заналхийллийг тээгч үзэл санаа, хүн, эд зүйлс ямар ч хяналт, шалгалтыг нэвтрэн гарах боломжтой. Гэхдээ ийм тохиолдолд маш цөөн, үзүүлэх нөлөө бага бол хилийн хяналт, шалгалт шаардлагын түвшинд байна гэж үзэж болох. Харин байн байн, тогтмол, их хэмжээгээр илрэх юм бол хил хамгаалах байгууллага үүргээ биелүүлж чадахгүй, хилийн халдашгүй дархан байдал алдагдаж буйг харуулна” гэжээ.





Дэлхий дахины хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшил болон бусад хүчин зүйлтэй холбоотойгоор улсын хилийн халдашгүй дархан байдлыг хөндөж буй аюул, заналхийллүүд, тэдгээрийн хэв шинж, арга ажиллагаа улам бүр өөрчлөгдсөөр байгаа өнөөгийн нөхцөлд өргөн уудам газар нутаг, цөөн хүн амтай манай орны хилийг хүн, хилчид дангаараа хамгаалах нь үр дүн багатай болж байна. Иймд орчин үеийн дэвшилтэт техник технологийг хилийн хамгаалалтад нэвтрүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Хил хамгаалалтын техник технологи олон улсын хэмжээнд маш өндөр түвшинд хөгжиж, өндөр технологид суурилсан хяналтын, дохиоллын, радарын гэх мэт техник хэрэгслүүдийг хэдийн ашиглаад эхэлсэн.

Иймд, хилийн шуурхай мэдээллийн системийг орчин үеийн технологи ашиглан идэвхжүүлэхэд техник технологийн шинэчлэл, инновац нэвтрүүлэх ёстой. Ингэхдээ мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах систем бүрдүүлэн, улмаар сансрын технологи ашиглан хилээ бүхэлд нь хянах боломжийг судлан нэвтрүүлэхийг зорьж байна. Тухайлбал, ОХУ сансрын холбооны системээр хилийн зурвасын дагуу бүхэлд нь хяналт тавьдаг. Мөн АНУ, Канад хоёр хамтын хяналтын систем буюу “Нэг цонх”-ны үйлчилгээ нэвтрүүлсэн. Европын холбооны орнууд ч хилээ нэгдсэн хүч, зохион байгуулалтаар, дундын мэдээллийн санд үндэслэн хамгаалж байна. Энэ мэт арга, туршлагыг судалж, өөрийн орны онцлогт тохируулан хилийн хамгаалалтыг орчин үеийн бөгөөд олон улсын жишигт нийцүүлэх юм. Мөн техник технологийн дэвшлийг өргөн хүрээнд нэвтрүүлж болох хэсэг нь хилийн боомт. Тэдгээрийн аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх

Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо, дохиолол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг "улсын хил хамгаалах зориулалттай инженер техникийн байгууламж" гэнэ.

ОХУ хилээ бүх нийтээр хамгаалах зарчим баримталдаг бол БНХАУ хоёр улс-нэг хил буюу хамтын ажиллагааны хүрээнд хамгаалдаг.

Хил орчмын нутаг дэвсгэрийн өргөнийг улсын хил хамгаалах байгууллага тухайн нэгжийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр улсын хилийн шугамаас 100 км-ээс илүүгүйгээр тогтооно.

үйл ажиллагааг сайжруулж, технологийн давуу тал бүхий хяналтыг нэвтрүүлэх юм. Үүнийгээ мэргэшсэн гэрээт хилчний ур чадвар, арга туршлагатай хослуулан, хойшид хүний нөөцөө бэхжүүлэхэд анхаарч чадвал дархан хил маань дандаа амгалан байх том хөшүүрэг болох юм. Үүний тулд хил хамгаалалтын дүрмийг шинэчилж, зөрчил, хууль бус ажиллагаатай тэмцэх арга тактикаа бүсийн онцлогт тохируулах хэрэгтэй болж байна.

Гэхдээ нөгөө талаас манай улс торон саад, хамгаалалт болон улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжаа шинэчилж, хилчдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны ус, эрчим хүчээр хангах шаардлагатай юм. Мөн хилийн бүс нутгийг эзэнтэй байлгаж, хил орчмын бүс нутагт амьдарч байгаа иргэдэд төрийн үйлчилгээг бүрэн дүүрэн хүргэх нь төрийн бодлогын салшгүй хэсэг билээ. Түүнчлэн алслагдсан хилийн хэсэгт отряд, застав шинээр байгуулж, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэхэд анхаарч байна. Хилчид тус бүс нутагт амьдарч буй иргэдээ илүүтэй дэмжих бодлого, тогтолцоотой байхыг чухалчилж байна. Монгол Улсын хил орчмын бүс нутагт амьдарч буй иргэд хил хамгааллын үйл ажиллагаанд туслах хүчний үүргээр идэвхтэй, мэдлэгтэй оролцож, сонор сэрэмжтэй байж, зөрчил, халдлагыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд хилчдээс дутахгүй үүрэг гүйцэтгэж ирсэн бахархам, баатарлаг түүхтэй билээ.





УЛСЫН ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

Улсын хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байх бөгөөд хилийн цэрэг нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хилийн цэргийн штаб, анги, салбар, зэвсэглэл, техник, ар тал, хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжээс бүрдэнэ.

Хилийн цэргийн анги, салбарын тоо, байршил, зэрэглэлийг хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах эрх ашигт нийцүүлэн тэдгээрийн хилийн анги, салбартай харьцангуй ижил хэмжээнд байх зарчим баримтлан Засгийн газар тогтоодог.

Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, бүс нутгийн цэрэг, улс төр, нийгэм, эдийн засгийн байдал, хөрш орнуудын хилийн нөхцөл байдлын өрнөлт, уламжлалт хилийн зөрчлүүдээс гадна уламжлалт бус хилийн зөрчлүүд тэдгээрийн төрөл, хэлбэр өсөх хандлагатай болов. Сүүлийн үед хар тамхи, мансууруулах бодис, зэвсэг галт хэрэгсэл, хүний наймаа, хориглосон бараа бүтээгдэхүүн, эрдэс баялаг, палеонтологийн болон түүх соёлын эд өлгийн зүйлс, алт, үнэт чулуу, байгалийн ховор олдвор, амьтан, ургамлын гаралтай эд эрхтэн зэргийг хууль бусаар, зохион байгуулалттай хил нэвтрүүлэх зэрэг зөрчил шинэ сорилт болж гарч ирж байна. Эдгээртэй улсын хил хамгаалалтын арга тактикийг боловсронгуй болгох, орчин үеийн дэвшилтэт техник технологийн ололтыг нэвтрүүлэх, хилийн албыг цахим болгон хөгжүүлэх, хилчдийг мэргэшүүлэх замаар тэмцэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Монгол улсын хил хамгаалалтыг хөрш орнуудын түвшинд хүргэж, улсын хилийг агаараас хянах системд шилжүүлэн, хиймэл дагуулыг ашиглах юм. Тухайлбал, улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологи дохиолол, хяналт хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж хангах болно. Улмаар орчин үеийн дэвшилтэт технологид тулгуурласан Монгол улсын хил хамгаалалтын удирдлагын төвийг байгуулна.

Хил хамгаалах ерөнхий газар нь “Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр”-ийн хүрээнд говь цөлийн, тал хээрийн, уулын, ой тайгын бүсийн байгаль, цаг уур, физик газарзүйн онцлог нөхцөлд зохицсон хил хамгаалалт, хангалтын тогтолцоонд шилжүүлж, хил хамгаалалтын мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг ханган, орчин үеийн зэвсэг, техник технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Зураг 9. Монгол Улсын хилийн урт, дөрвөн захын цэг

ХИЛИЙН УРТ
8,252.658 км

**МОНГОЛ УЛСЫН
ХОЙД ЗАХЫН ЦЭГ**
Хөвсгөл аймгийн
Цагааннуур сумын нутагт
2091.6 тоот өндөрлөг

**МОНГОЛ УЛСЫН
БАРУУН ЗАХЫН ЦЭГ**
Баян-Өлгий аймгийн
Цэнгэл сумын нутагт
Монгол Алтайн нурууны
ус хагалбарын 3252.0 тоот
өндөрлөгөөс 3371.0 тоот
өндөрлөгийн хооронд

МОНГОЛ

БНХАУ-тай 4,709.658 км



МОНГОЛ УЛС-БНХАУ-ЫН ХИЛ

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн гэрээг 1962 онд байгуулж, хилийн дэглэмийн гэрээг 1988, 2010 онд тус тус шинэчлэн, анхны хамтарсан шалгалтыг 1982-1984 онд, хоёр дахь удаагийн хамтарсан шалгалтыг 2001-2004 онд зохион байгуулсан. Монгол, Хятадын улсын хилийг 1975 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагад бүртгүүлсэн бөгөөд "Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай гэрээ"-г 1988 онд байгуулж, 2010 онд шинэчлэн батламжилсан.



ОХУ-тай 3,543 км



МОНГОЛ УЛС-ОХУ-ЫН ХИЛ

Монгол Улс, Оросын Холбооны Улсын хилийг хоёр улсын хооронд 1958, 1976 онд байгуулсан хилийн гэрээний дагуу газар дээр нь тогтоож, анх удаагийн хамтарсан шалгалтыг 1987-2001 онд явуулсан. "Монгол, Оросын улсын хилийн дэглэмийн тухай гэрээ"-г 1980 онд байгуулж, 2006 онд шинэчлэн батламжилсан. Энэхүү гэрээний дагуу улсын хилийн хамтарсан шалгалтыг 2022 оноос эхлүүлж байна.



МОНГОЛ УЛСЫН ЗҮҮН ЗАХЫН ЦЭГ

Дорнод аймгийн
Халхгол сумын нутагт
Соёлз уулын Модтой
хамрын 1292.5 тоот
өндөрлөг



УСААР

901.058 км



ХУУРАЙ ГАЗРААР

7,351.6 км

**МОНГОЛ УЛСЫН
ӨМНӨД ЗАХЫН ЦЭГ**
Өмнөговь аймгийн
Номгон сумын нутагт
Орвог гашууны Бор
толгойн 799.9 тоот
өндөрлөг

Эх сурвалж: Хил хамгаалах ерөнхий газар, 2022

ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ХИЛ ХАМГААЛАЛТ



Улсын хил хамгаалалтад тухайн бүс нутгийн уугуул оршин суугчид, иргэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Хил хамгаалах байгууллагын анги, нэгтгэлүүд хариуцсан нутаг дэвсгэртээ улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийг зохион байгуулдаг. Туслах хүчний гишүүд хил орчмын нутаг дэвсгэрт байнга болон түр оршин суугаа болон ажил үйлдвэрлэл явуулж байгаа байршлаасаа улсын хил хамгаалалтад оролцож, хяналт, ажиглалт хийх, илрүүлсэн зөрчлийг цаг тухайд нь мэдэгдэх, хилийн зурвас, боомт, бүсэд мөрдөх журмын биелэлтэд хяналт тавих, цагийн байдлын дагуу шуурхай ажиллахад бэлэн байх, мал бэлчээрээр хил давахаас урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг гүйцэтгэнэ. Тухайн нутаг эзэн хүнтэй, оршин суугчтай, амьдрал ахуйтай гэдгийг илтгэж байх, эзэнгүйдэж орхигдохоос сэргийлэхийн тулд тодорхой бодлого хэрэгжүүлж, нутаглах, суурьших явдлыг дэмжих юм.





УХААЛАГ ШАЛГАН НЭВТРҮҮЛЭЛТ



Монгол Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологи дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлэх нь тэргүүлэх зорилтуудын нэг юм. Улсын хилээр нэвтэрч буй иргэд, зорчигчдын биеийн давтагдашгүй өгөгдөл болох хурууны хээ, нүүрний зургийн тоон мэдээллийг авч, биометрик мэдээллийн нэгдсэн санд бүртгэснээр шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаа олон улсын жишигт хүрч, нэгж зорчигчид зарцуулах шалган нэвтрүүлэх ажиллагааны хурд 14-18 секунд болох юм. Байнга хил нэвтэрдэг хүнийг 10 секундэд шалгах боломжтой бөгөөд цаг хугацаа хэмнэснээр хил хамгаалах, шалган нэвтрүүлэх албадын үйл ажиллагааны бүтээмж эрс дээшилнэ.



АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

ХҮН, НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ

ЗОРИЛТ 7.3 Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлого, техникийн шийдэл, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулах үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Эрсдэлийг даван туулах, чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн аюулгүй байдлыг хангаж, бэхжүүлэх үе

МОНГОЛ УЛСЫН
УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй; эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

Монгол Улсын Үндсэн хууль, 16 дугаар зүйл


Гэмт хэргийн тоо улсын хэмжээнд сүүлийн хоёр жил дараалан буурчээ. Энэ нь Эрүүгийн хуулийг 2015 оны арванхоёрдугаар сард шинэчлэн баталснаас хойш анх удаа буурч байгаа үзүүлэлтүүд юм. Үүнийг цар тахлын улмаас тогтоосон олон удаагийн хөл хорио, хязгаарлалттай холбон тайлбарлах хүн цөөнгүй. Хэдийгээр 2019, 2020 болон 2021 оны эхний хагас жилийн байдлаар гэмт хэргийн гаралт ерөнхий дүнгээрээ буурсан ч зарим төрлийн, тухайлбал, авлигын, мөнгө угаах, хүн худалдах болон цахим гэмт хэргийн тоо 43 хүртэл хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн зөрчлийн тоо буурсангүй. Тодруулбал, 2019 онд 1.9, 2020 онд 2.2 сая, 2021 оны



эхний хагас жилийн байдлаар 758 мянган зөрчил бүртгэгдэв. Эдгээрээс 2.8 зөрчилд хамаарах 66 тэрбум орчим төгрөгийн торгууль төлөгдөөгүй байна. Тэгвэл гэмт хэргийн улмаас иргэд жилд 200 гаруй тэрбум төгрөгийн хохирол амсдаг гэсэн тооцоо бий. Түүнчлэн олон улсын гэмт хэргийн үзүүлэлтээр энэ оны эхний хагас жилийн байдлаар манай улс 56 оноо авч, Ази тивдээ эхний зургаад бичигджээ. Тивийн хэмжээнд эл жагсаалтыг үргэлжилсэн үймээнтэй байгаа Афганистан, Сири зэрэг орон тэргүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, дотоод болон гадаадын эдгээр тоон үзүүлэлт манай улсад гэмт хэргийн гаралт багагүйг баталж байна. Статистик бидэнд юу хэлж байна вэ? “Гэмт явдал нь нийгмийн хөгжлийн явцад улс төр, эдийн засаг, үзэл суртал, ёс суртахууны хүрээнд үүссэн элдэв гажуудал, зөрчил, сөрөг үзэгдлийн шууд үр дагавар болж, тооны буюу чанарын үзүүлэлтээр илэрхийлэгддэг өөрийн зүй тогтолтой, нийгэм, эрх зүйн үзэгдэл юм” хэмээн криминологичид тодорхойлдог. Тэгвэл дээрх тоон үзүүлэлтийн уг шалтгаан нь улс төр, эдийн засаг, үзэл суртал, ёс суртахууны хүрээнд үүссэн элдэв гажуудал, зөрчил, сөрөг үзэгдлүүд гэж үзэж болно.

Монгол Улс гэмт хэргийн индексээр 193 улсаас 143 дугаарт бичигджээ.

Зураг 10. Дэлхийн гэмт хэргийн үзүүлэлт



Эх сурвалж: The Global Organized Crime Index, 2022

АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ
НИЙГЭМ

ХҮН, НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ

Дэлхий дахинд

Facebook, Twitter, Instagram
зэрэг нийгмийн сүлжээг
ашиглан цахим гэмт хэрэг
үйлдэгчид жилд

3.25 тэрбум

ам.долларын хохирол
бусдад учруулдаг.

Иргэдийнхээ эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа хууль бус үйлдлээр зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, хамгаалах чиг үүргийг төр хүлээдэг. Үндсэн хуульдаа “...Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” хэмээн заасан. Хөндөгдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх, зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх замаар л нийгэмд шударга ёс, дэг журам тогтдог. Гэмт хэрэгтэй хийх тэмцлийн хамгийн эхний бөгөөд үр дүнтэй хэсэг нь түүнээс урьдчилан сэргийлэх явдал юм. Тиймээс гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах, улмаар урьдчилан сэргийлж, таслан зогсоох талаар цогц арга хэмжээ зохион байгуулах нь чухал бөгөөд үүнийг зөвхөн хууль сахиулагчид бус бүх шатны төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэг шаардлагатай. Иймд урт хугацааны хөгжлийн бодлогод энэ талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлэн, үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь бүх нийтийн үйл хэрэг байх ёстойг бүгдээрээ хүлээн зөвшөөрч, гар бие оролцох цаг болсон. Гэмт хэрэг үүсэх нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, ажилгүйдэл, ядуурал, архидалтыг бууруулахад төр-иргэд-олон нийтийн хамтын ажиллагаа, хичээл зүтгэл юу юунаас чухал. Гэр бүл, сургуулийн орчинд ёс зүйтэй, эрх зүйн зохих мэдлэгтэй иргэн бэлтгэж, соён гэгээрүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг үндэс суурь. Түүнчлэн нийгмийн харилцаа өөрчлөгдөж байгаагийн хэрээр хүрээгээ тэлж буй шинэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бусдын эрхийг зөрчихгүйгээр өөрийн эрх, эрх чөлөөг эдлэх талаарх суурь ойлголт, хандлагыг хүүхэд залуучуудад төлөвшүүлэх шаардлагатай болж байгааг харгалзан үзвэл зохилтой. Иймд хөгжлийн бодлогын хяналт, хамгаалалтын болон хууль сахиулах байгууллагуудын шинжлэх ухаанч хамтын ажиллагааг хангахаар тодорхой зорилго, зорилтуудын дэвшүүлээд байна.

Тухайлбал, хүүхэд, залуучуудыг цахим орчин дахь гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, хамгаалах шаардлага сүүлийн үед зүй ёсоор тулгарч байна. Тэр дундаа нийгмийн сүлжээ, ялангуяа цахим орчинд хүүхдүүдийн зүй зохистой хэрэглээний мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа нь хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан болж байна. Нийгмийн сүлжээний нийт хэрэглэгчийн 51.7 хувь нь 20 хүртэлх насны хүүхэд, залуучууд байгаа бөгөөд тэдний 92 хувь нь зөвхөн фэйсбүүк ашигладаг гэсэн судалгаа бий. Тэд цахим орчинд зохисгүй контент үзэх, дэлгэцийн хамааралтай болох, сэтгэл зүйн болон бэлгийн шинжтэй дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч болох зэрэг эрсдэлтэй нүүр тулж байна. Иймд цахим контентын агуулгыг хэрхэн ялгах, насанд хүрэгчдийн, хууль бус, зохисгүй агуулгатай зүйлсэд өөрсдөө хяналт



Хүснэгт 1. Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирсон, гэмтсэн, нас барсан хүний тоо

	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
ХОХИРСОН	27,689	37,173	33,566	30,782	23,050
ГЭМТСЭН	11,257	10,513	9,283	8,727	8,175
НАС БАРСАН	880	1129	934	930	670

Эх сурвалж: УЦХ, 2021

тавьж, зайлсхийх, фэйсбүүк орчинд найзаа хэрхэн сонгох, аюултай хүмүүст боломж олгохгүй байх талаар хүүхэд, залуучуудад тайлбарлан, ойлгуулах нь чухал. Түүнчлэн хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг цахим орчноор дамжуулан үйлдэх нь олонтоо бөгөөд хохирогчдын дийлэнх нь охид, эмэгтэйчүүд байдгийг анхаарч сэрэмжлүүлэх хэрэгтэй байна. Иймээс хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөлөх арга хэмжээг нийгмийн байгууллага, төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдын дунд ч эмэгтэйчүүд, хүүхдүүд жин дарж байна. Энэ төрлийн хүчирхийлэл нь байнга давтагдан даамжирдаг, улмаар ноцтой үр дагаварт хүргэдэг. Хүчирхийлэлд өртөгчдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байр, нэг цэгийн төвүүд ажилладгийг хохирогчид мэддэггүй, мэдсэн ч тэвчиж, хүлцэж, чимээгүй байсаар багагүй хугацааг өнгөрүүлсэн байдаг байна. Тиймээс энэ асуудлыг шийдвэрлэх хүрээнд гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэлзүйн засал нийгмийн тусламжийн үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлэхийг зорьж байна.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга замуудын нэг нь нийтийн эзэмшлийн бүсийг камержуулах юм. Ингэхдээ хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, хязгаарлахгүйгээр хэрэгжүүлэх нь чухал. Үүнийг ч Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд үндсэн зарчим болгон тусгасан бөгөөд нийслэл, орон нутгийн төвүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерын нэгдсэн төв бий болгож, мэдээлэл харилцаа холбоо, барилга байгууламжийн дэд бүтцийг орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхээр тодорхойлсон юм.


- Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим:
1. хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
 2. нууцлалыг хамгаалах;
 3. шуурхай байх;
 4. хамтран ажиллах.

Монгол Улс газар хөдлөлтийн эрсдэлийг зайлшгүй тооцоолж, урьдчилан сэргийлж байх ёстой.

ГАМШГААС СЭРГИЙЛЭХ МЭДЭЭЛЛИЙН САН

Нийгэм амар тайван байх эсэхэд байгалийн болон хүний оролцоотой гамшиг, ослоос сэргийлэх нь томоохон байр суурь эзэлдэг. Сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн газар хөдлөлтийн судалгаагаар манай улсын нийт хот, суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн долоо ба түүнээс дээш баллын чичирхийллийн бүс нутагт оршиж байгааг тогтоожээ. Эдгээр газар нутагт нийт хүн амын 85 гаруй хувь нь амьдарч байна. Мөн манай орны хувьд хамгийн түгээмэл тохиолддог байгалийн гамшиг нь зуд. Тухайлбал, Монгол орны нутаг дэвсгэрт сүүлийн 60 гаруй жилийн 65 хувьд нь их, бага хэмжээтэй зуд тохиолдсон байна. Статистик судалгаанаас үзэхэд тохиолдож буй зудын улмаас жил тутам дунджаар 1.3 сая толгой мал хорогджээ. Сүүлийн үед гамшигтай тэмцэх үйл ажиллагаанаас илүүтэйгээр урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тооцох нь илүү үр дүнтэй байна гэсэн хандлага руу дэлхий нийтээрээ шилжиж байна. Тухайлбал, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан нэг ам.доллар гамшгийн дараа хариу арга хэмжээ авахад зарцуулах 7-9 ам.долларын зардлыг хэмнэнэ гэсэн тооцоог судлаачид хийсэн байдаг.

Зураг 11. Монгол орны газар хөдлөлтийн эрсдэлийн зураг



Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний Хөгжлийн газар, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага (ЖАЙКА), 2021



Тэгвэл гамшгаас урьдчилан сэргийлэх арга замуудын нэг нь гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх явдал юм. Гамшгаас хамгаалах тухай хуульд гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх талаар тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүн, санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглах, мэдээлэх, нийтийн хүртээл болгох, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ гэж заажээ. Гамшгийн мэдээллийн санд:

1. Гамшгийн эрсдэлтэй нутаг дэвсгэрийн газарзүйн мэдээлэл
2. Гамшигт нэрвэгдэж болзошгүй хүн ам, дэд бүтцийн бүртгэл, мэдээлэл
3. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын болон хохирлын дүн мэдээ
4. Бусад мэдээллийг багтаадаг.


Иргэд мэдээлэлтэй байснаар гамшгийн үед өөрийн амь нас, эрүүл мэндийг болзошгүй аюулаас авраад зогсохгүй эргэн тойрондоо хамт буй хүмүүст тусалж чадна.



Монгол Улс байгалийн гамшиг тохиолдох эрсдэлийн магадлалаар дэлхийн 171 орноос 30 дугаарт буюу маш бага эрсдэлтэй орны тоонд эрэмбэлэгджээ.



Зураг 12. Гамшгийн менежмент



ГАМШГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ:

- БЭЛТГЭХ** Хэрхэн хариу үзүүлэхээ төлөвлөх.
- ХАРИУ ҮЗҮҮЛЭХ** Гамшгийн улмаас үүсэх аюулыг багасгах хүчин чармайлт
- СЭРГЭЭЛТ** хэвийн байдалд оруулах.
- УРЬДЧИЛСАН НӨЛӨӨЛӨЛ** гамшгийн хохирлыг бууруулахад чиглэсэн урьдчилсан нөлөөлөл

УЛАМЖЛАЛТ БУС АЮУЛЫН ЭСРЭГ



Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны арваннэгдүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг 2001 оны тавдугаар сарын 31-ний өдрийн протоколд тус тус нэгдэн ороод байна. Цаашид үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Зураг 13. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ хэрэгжүүлж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна.



Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.



Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг нийгмийн байгууллага, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.



Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх нэгжийн бүтэц, орон тоог өргөжүүлж, чадавхыг нэмэгдүүлэх, уг гэмт хэргийн улмаас хууль бусаар гадагш гарсан хөрөнгийг царцаах, буцаан авах талаар хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, сургалт, мэдээлэл солилцох арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.




ЦАХИМ ГЭМТ ХЭРГЭЭС СЭРГИЙЛЭХ ЧАДАМЖ



Цахим гэмт хэрэг нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгт тооцогддог бөгөөд дэлхийн эдийн засагт жилд дунджаар 1.0 их наяд орчим ам.долларын хохирол учруулдаг байна. Уг гэмт хэргийг үйлдэгчдийн тоо жил бүр нэмэгдэж, арга хэлбэр нь нарийсаж байна. Иймд цахим гэмт хэрэг гэж юу болох, түүний онцлог шинж чанар, гэмт этгээдүүдийн үйл ажиллагааны талаар ойлголт, мэдээлэлтэй болсноор хохирогч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой юм. “Facebook”, “Twitter” зэрэг нийгмийн сүлжээг ашиглан цахим гэмт хэрэг үйлдэгчид дэлхий дахинд жилд 3.25 тэрбум ам.долларын хохирол бусдад учруулдаг бөгөөд хохирогчдын тоо жил бүр нэмэгдсээр байна. Цахим гэмт хэргийн хамгийн түгээмэл хэлбэрүүдэд “фишинг” буюу интернэтээр залилан үйлдэх, “сошиал инженерчлэл” буюу хувь хүний сэтгэлзүйн онцлогийг харгалзан сэдэл /мөнгө хожих, тэтгэлэг авах зэрэг/ өгч, итгэл төрүүлэх замаар мэдээлэл цуглуулах, нууцад нэвтрэх болон компьютерын сүлжээнд төрөл бүрийн вирус, хортой код тараах зэрэг аргууд багтдаг. Үүнээс гадна цахим шуудан ашигладаг нийт хэрэглэгчдийн хувьд спам халдлага хамгийн эрсдэлтэйд тооцогдож байна.

Кибер гэмт хэргийн бүлэглэлүүд нь Моррис Вормоос эхлэн өндөр үр ашигтай золионы хэрэгсэл хүртэл зохион байгуулалттай гэмт хэрэг болтлоо хувьсан өөрчлөгдсөн. Олон улс орон үүнийг зогсоох чиглэлээр ажиллаж байгаа ч арга хэрэгслээ өөрчлөн улс үндэстэн, бизнест сөрөг нөлөөлөл үзүүлсээр байна.



АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ХӨГЖИЛ

ЗОРИЛТ 7.4 Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг бааз, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Хууль сахиулах салбарын бүтээн байгуулалтыг дэмжиж иргэдэд үзүүлэх үйлчилгээний найдвартай, шуурхай байдлыг бэхжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Өндөр технологид суурилсан үндэсний чадавхыг хөгжүүлж, аюулгүй байдлыг хөгжингүй улсын түвшинд ойртуулах үе



Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

Хууль цаазын өнө эртний уламжлалтай монголчууд бидний хувьд хуулийн засаглал шинэлэг зүйл биш билээ.

Хууль дээдлэх ёсны (Rule of law) тухай үзэл санаа Аристотэлоос эхтэй бөгөөд тэрээр сайн дэг журам тогтсон нийгмийг иргэд биш, хууль удирдах ёстой гэж сургасан. Харин орчин үед үүнийг хуулийн өмнө бүх иргэн ижил тэгш эрхтэй, нөгөө талаас төр албадлагын хүчийг дур зоргоор ашиглахгүй байх нөхцөлийг хангаж буй механизм, үйл явц, байгууллагууд, хэм хэмжээ хэмээн тайлбарлаж байна. Хууль дээдлэх ёсыг энгийнээр хууль батлах, түүнийг хэрэгжүүлэх, эрх зүйн бусад хэм хэмжээ хоорондын харилцаа нь гагцхүү хуулиар зохицуулагдахыг, хэн ч хуулийн өмнө тэгш эрхтэй байхыг ойлгож байна. Эл үзэл санааг сүүлийн үед “хүн биш, хууль засагладаг нийгэм” хэмээн тодорхойлж, ярих болсон нь ойлгомжтой ч байж мэднэ.

Хуулийн хэрэгжилтийг хангуулж, хэлбэрэлтгүй мөрдүүлэх хүмүүс бол хууль сахиулагчид. Төрийн албаны тухай хуульд заасанчлан тэд бол хүн амын болон үндэсний аюулгүй байдлыг



Зураг 14. Хууль дээдлэх байдлын үзүүлэлт


МОНГОЛ

Бүс нутаг: Зүүн Ази болон Номхон далай
Орлогын түвшин: Бага, дунд

Оноонууд 0-1 хороонд үнэлэгдэнэ. 1 бол хамгийн өндөр оноо, 0 нь хамгийн бага оноо.

Нийт оноо	Бүс нутгийн зэрэглэл	Орлогын зэрэглэл	Дэлхийн жагсаалт	Онооны өөрчлөлт	Зэрэглэлийн өөрчлөлт
0.54	8/15	3/35	61/139	0.01 ▲	3 ▲

	Оноо	Онооны өөрчлөлт	Бүс нутгийн зэрэглэл	Орлогын зэрэглэл	Дэлхийн жагсаалт
Засгийн газрын эрх мэдлийн хязгаарлалт	0.54	0.01	9/15	6/35	66/139
Авлигаас ангид	0.43	0.01	12/15	9/35	81/139
Нээлттэй засгийн газар	0.50	0.01	9/15	9/35	72/139
Үндсэн эрх	0.58	0.01	7/15	4/35	63/139
Нийгмийн хэв журам ба аюулгүй байдал	0.76	-0.01	10/15	6/35	58/139
Зохицуулалтын хэрэгжүүлэлт	0.50	0.03	9/15	8/35	70/139
Иргэний шударга ёс	0.55	0.02	8/15	4/35	63/139
Эрүүгийн шударга ёс	0.49	0.00	8/15	1/35	57/139



* 10% дээр статистикийн чухал ач холбогдолтой өөрчлөлтийг харуулж байна

Бага Дундаж Өндөр 2021 оны оноо 2020 оны оноо

Эх сурвалж: World Justice Project, 2022

хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчид. Тодруулбал, прокурор, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шинжилгээний болон шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх, хүний эрхийг хамгаалах зэрэг чиг үүрэгтэй байгууллагын алба хаагчид үүнд хамаарах юм.

Хуулийн байгууллага, түүний алба хаагчид эх орон, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнч байж, хариуцсан ажилдаа чин шударгаар хандан, хичээн зүтгэж ажилласнаар олон нийтийн хүндэтгэл, хайрыг хүлээж, итгэл, дэмжлэгийг авах билээ. Аль ч улсын ирээдүй эдийн засгийн хөгжлөөс илүүтэй хууль сахиулах тогтолцооноос хамаарч тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл, эдийн засаг нь тогтвортой хөгжих хөшүүрэг нь иргэн төвт эрх зүйн тогтолцоо, хэрэгжилтийг нь, шударга ёсыг хангадаг хууль сахиулах салбар байдаг. Хууль сахиулах салбарын үйл

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй бөгөөд хуулийг хангуулах, биелүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцооны үйл ажиллагааны байдал нь шударга ёсны үзүүлэлт болдог.

ажиллагааны үндсэн зарчим нь Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, иргэн, олон нийтийн эрхийг хангах, зөрчигдсөн тохиолдолд сэргээж, хамгаалах явдал юм.

Хууль дээдлэх зарчмын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн олон улсын болон дотоодын байгууллага, судалгаа нэг бус бий. Тодруулбал, олон улсын түвшинд Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтээр улс, орнуудыг өмчлөх эрх, гэрээний хэрэгжилт, хувь хүний болон өмчийн аюулгүй байдал зэрэг хэмжүүрээр эрэмбэлдэг бол Дэлхийн шударга ёсны төслөөс хууль дээдлэх ёсыг найман үзүүлэлт (төр засгийн эрх мэдлийг хязгаарлах, авлигаас ангид байх, нээлттэй засаг, суурь эрхүүд, дэг журам ба нийгмийн аюулгүй байдал, зохицуулалтын дүрэм журмын хэрэгжилт, иргэний болон эрүүгийн шүүн таслах ажиллагаа), 44 дэд үзүүлэлтээр тухайн орны олон нийт болон экспертийн саналд үндэслэн тогтоодог.

Зураг 15. Хууль дээдлэх ёсны үндсэн зарчим



Хууль дээдлэх гэдэг нь бүх хүн, байгууллага, аж ахуйн нэгж хууль тогтоомжийн өмнө хариуцлага хүлээдэг засаглалын зарчим юм. Хууль дээдлэх зарчим нь хууль өөрөөрөө тодорхойлогдон, баталгаажиж хүн бүрд адил тэгш үйлчилнэ гэсэн утгатай.



Эдгээр үзүүлэлтээр 2021 онд дэлхийн 139 орныг эрэмбэлэхэд Монгол Улс 61 дүгээрт оржээ. Уг үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдээс хамгийн доогуур оноотой нь төрийн албаны авлига, ил тод байдал болон хууль, тогтоомжийн сул хэрэгжилт, шударга ёсны тогтолцооны үзүүлэлт байна. Нийгэмд нэгэнт бий болсон шударга ёсны хүсэмжлэл хийгээд олон улсад хэрэглэгддэг энэ мэт үнэлгээ нь хууль сахиулах салбарыг тодорхойлдог.

Иймд алба хаагчдаа мэргэшүүлж, олон улсын жишгээр хөгжүүлэн чадавхжуулах нь хууль сахиулах салбарын үйл ажиллагаа, тэдний ажлын стандарт, эрх зүйн орчин, хандлага, арга барил, ёс зүй зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Мэдээж энд тэдний цалин хангамж, нийгмийн баталгаа ч хамаатай. Бас дэвшилтэт техник технологи, мэдлэгт суурилсан, инновац шингэсэн бодлогыг орхигдуулж болохгүй. Тухайлбал, “камержуулалт” гэгдэх болсон телекамерын хяналтын нэгдсэн систем нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлд үр дүнтэй болох нь хүлээн зөвшөөрөгдөөд буй. Түүнчлэн ажлын орчин, зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт, стандартыг сайжруулах зайлшгүй шаардлага бий. Хамгийн гол нь хууль дээдлэх ёсыг хангах, иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нэгдмэл бодлого хууль сахиулах салбарт биелж байх нь чухал.

Хууль сахиулагчид бодлого, үйл ажиллагаа, арга барилаа нийгмийн хөгжил, хувьсан өөрчлөгдөж байгаа цаг үе, амжилт, ололт, алдаа сургамжийн аль алинтай нь уялдуулан хөгжүүлэх шаардлагатай. Цаг үе өөрчлөгдөхийн хэрээр хууль сахиулагчид, уламжлалт бус, шинэ төрлийн гэмт хэргийг үйлдэж буй этгээдүүдээс түрүүлж сэтгэж, давж, отож, урьдчилан сэргийлж ажиллах шаардлага үүснэ. Тиймээс хууль сахиулах байгууллагын эдийн засгийн орчин, материалаг баазыг улам бэхжүүлэн чадварлаг хүний нөөцөөр тасралтгүй сэлбэн ажиллахыг үндсэн чиглэл болгон салбарын хүрээнд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэхийг зорьсон. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан байгуулах, хиймэл оюунд суурилсан технологийн дэвшлийг нэвтрүүлэх, ДНХ, хими, физик, биологийн лабораториудыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, лабораториудад шинжилгээ хийх шинэ арга, аргачлал нэвтрүүлнэ. Криминалистик, шүүх эмнэлэг, тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник технологийн дэвшлийг хослуулж ажиллах орчин, нөхцөлийг сайжруулахыг зорьж байна. Энэ бүхний дүнд 2050 он гэхэд өндөр технологид суурилсан үндэсний чадавхыг хөгжүүлж, аюулгүй байдлыг хөгжингүй улсын түвшинд ойртуулах зорилт биелэгдэх юм.



Латин гаралтай *Pacta sunt servanda* хэмээх нь гэрээг заавал биелүүлэх ёстой гэсэн утгатай эрх зүйн хэллэг юм. Гэрээ, контракт ба түүнийг заавал биелүүлэх үүрэг бол Өрнийн эрх зүйн үндэс бөгөөд хууль сахиулах салбарын нэгэн мөрдлөг болдог.



Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах, хулгайлах, залилах, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, хууль бусаар мод бэлтгэх, алдуул мал, гээгдсэн хөрөнгө завших, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих гэх мэт хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүнд зорчих эрхийг нь хязгаарлах ял ноогдуулна.


ЯЛЫН ЦАХИМ ХЯНАЛТ

Манай улс 2015 онд Эрүүгийн хуулиа шинэчлэхдээ зорчих эрхийг хязгаарлах ялыг хуульчилсан ч 2021 оны эхнээс мөрдөж эхлэв. Учир нь уг ялыг хэрэгжүүлэхийн тулд хүний нөөцөө бүрдүүлж, чадавхжуулах ажлыг зохион байгуулснаас гадна ялтанд зүүлгэх гав гинж бугуйвч, шаардлагатай хяналтын мэдээллийн системийг хөгжүүлэх гэж нэлээд хугацаа зарцуулсан юм.

Шүүхээс хэрэгтний явах маршрутыг тогтоож өгөх бөгөөд ял эдэлж буй хүн тухайн чиглэлээс гарч, хориглосон бүс рүү явж байгаа бол түүнийг хариуцсан шийдвэр гүйцэтгэгч ажилтанд дохиолол очих юм. Улмаар шийдвэр гүйцэтгэгч нөхцөл байдлыг хуулийн хүрээнд хянаж, нягтлаад, дараагийн шатны арга хэмжээг авах хуулийн зохицуулалттай. Шийдвэр гүйцэтгэгч нар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтны талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж, техникийн зааварчилгаа өгөхөөс гадна хувийн баталгаа гаргуулан авдаг. Түүнчлэн цахим бугуйвчны нөөц цэнэг хураагуур, залгууруудыг ялтанд хүлээлгэн өгч, хяналтын цахим мэдээллийн системд бүртгэдэг.

Ийм ялаар шийтгүүлсэн хүнийг хянах Цахим хяналтын төвийг байгуулаад байна. Энэ төрлийн ялыг дэлхийн 40 гаруй оронд хэрэглэдгээс 30 орчим нь манайх шиг цахим бугуйвч буюу гав ашиглаж байна. Цахим бугуйвчийг анх АНУ-д 1983 оноос хэрэглэсэн бол Англи, Швед, Голланд, Франц, Бельги, Канад, Австри, Швейцар, Герман, Португал, Итали, Израил, Эстони, Орос, Турк, Сингапур зэрэг улс өдгөө ашиглаж байна.

Зураг 16. Цахим гав ба дөнгө





Цахим хяналтын төвөөс 24 цагаар ялтныг хянадаг. Техникээс гадна шийдвэр гүйцэтгэгч нар биечилсэн хяналтыг давхар тавьж ажилладаг. Зорчих эрхийг хязгаарлах нь хөнгөн ялаар шийтгүүлсэн хүмүүсийг цахимаар хянаж, техникийн тусламжтайгаар зорчих эрхийг нь хязгаарлан, ялтан гэр бүлтэйгээ байж, ажил хийх, сурч боловсрох эрхийг нээлттэй байлгаж, нийгмийн оролцоог нь хангадаг. Улмаар хорих зардал багасах бөгөөд ойролцоогоор жилд гурван тэрбум төгрөг хэмнэх боломжтой хэмээн тооцсон. Зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлснээр Монгол Улсын эрүүгийн ялын бодлогыг шинэчлэх суурь тавигдсан гэж хууль сахиулах салбарынхан үнэлж буй.

Эрүүгийн хуульд заасан 206 төрлийн гэмт хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ял ногдуулахаар зохицуулжээ. Ингэхдээ хэрэгт холбогдсон хүний зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн байдал, нийгэмд учруулсан хор уршгийг харгалзан үздэг. Өөрөөр хэлбэл, заавал хорих ял оноож, бусад гэмт хэрэгтэнтэй хорихыг чухалчлахгүй юм. Ингэснээр хорих ялаас гадна давтан гэмт хэргийн тоо буурдаг аж. Одоогоор энэ төлийн ялаар шийтгүүлсэн ялтны дийлэнх хувь нь хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам, байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх, зөвшөөрөлгүй улсын тусгай хамгаалалттай газар нутгаас мод бэлтгэх журам зөрчсөн, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулж, залилах, хулгайлах гэмт хэрэгт шийтгүүлжээ. Цаашид Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор “Цахим хяналтын төв”-ийг байгуулж, пробацийн тогтолцоог хөгжүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын технологийн дэвшлийг инновацад суурилан хөгжүүлэх зорилтыг хангах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.



Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх хугацаандаа хориглолт, хязгаарлалтыг зөрчих, цахим бугуйвчийг таслах, гэмтээх зэрэг зөрчил гаргасан тохиолдолд эхний ээлжид сануулга өгч, энэ зөрчлөө дахин давтах, хориглолт хязгаарлалтыг ноцтой зөрчих тохиолдолд уг ялыг хорих ялаар сольж эдлүүлнэ.



ОЮУНЫ ӨМЧИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН



Оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудлын хүрээнд патент, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхүүд, газарзүйн заалтууд, шударга бус өрсөлдөөнийг хориглох гэх мэт өргөн хүрээтэй асуудлууд багтдаг. Энэ нь хүний эрхийг хангах, хөрөнгө оруулалтын урсгалыг дэмжих зэрэг нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой, нарийн төвөгтэй харилцаа юм.

Эрх зүйн нэгдсэн систем болон оюуны өмчийн салбарт хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын системийг нэвтрүүлж, боловсронгуй болгосноор шинжлэх ухаан, инновац, бүтээлч үйлдвэрлэлийн салбар эрчимтэй хөгжих суурь нөхцөл хангагдана. Улмаар бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, цахим гэрээ, хэлцлийн хууль, эрх зүйн орчныг сайжруулан цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, оюуны бүтээлийн зохиогч, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих хууль, эрх зүйн орчин иж бүрэн болох юм.

Зураг 17. Оюуны өмчийн эрх






ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛ




Шинжилгээний лабораториудад шинжилгээ хийх шинэ арга, аргачлалыг нэвтрүүлж, ДНХ, хими, физик, биологийн лабораториудыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, метохонд, бактериологийн шинжилгээний лабораториудыг шинээр байгуулна. Криминалистик, шүүх эмнэлэг болон тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлэн, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулна.

Зураг 18. Шүүхийн шинжилгээний шинэчлэл



Шинжилгээний лабораториудад шинжилгээ хийх шинэ арга, аргачлалыг нэвтрүүлж, ДНХ, хими, физик, биологийн лабораториудыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, метохонд, бактериологийн шинжилгээний лабораториудыг шинээр байгуулна.



ДНХ-ийн нэгдсэн сан бий болгож, эрэн сурвалжлах болон нууц далд аргаар үйлдсэн, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэхэд ашиглана.

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ЗОРИЛТ 7.5 Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Цахим мэдээллийн болон мэдээллийн технологийн инновацыг хөгжүүлж, үндэсний чадавхыг нэмэгдүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Цахим мэдээллийн болон мэдээллийн технологийн инновацыг хөгжүүлж, үндэсний чадавхыг нэмэгдүүлэх үе

МОНГОЛ УЛСЫН
“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-Д
МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ОНЦГОЙЛОН АЧ ХОЛБОГДОЛ
ӨГЧ ТОДОРХОЙЛСОН.

Мэдээллийн аюулгүй байдал бол улс орон бүрийн үндэсний аюулгүй байдлын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Орчин цагт мэдээллийн аюулгүй байдал улс орны нийгмийн олон талт харилцааг хамран улс төр, эдийн засаг, технологийн хурдтай шийдэл шаардаж улам өргөжин тэлсээр байна.

Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д мэдээллийн аюулгүй байдлыг онцгойлон ач холбогдол өгч тодорхойлсон. Мэдээллийн аюулгүй байдлыг цогцоор нь мэдээлэл нууцлагдмал, хүртээмжтэй, бүрэн бүтэн байх шинж чанарыг хангах ёстой гэж үздэг. Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бодлого, эрх зүйн зохицуулалт, стандарт, удирдлага, зохион байгуулалт, сургалтын тогтолцоо гэж тодорхойлсон. Уг үндсэн зорилтуудыг хангахдаа,

Нууцлагдмал байдлын чиглэлээр: Кибер аюулгүй байдлын тухай хууль, аюулаас хамгаалах, халдлагатай тэмцэх чадавх бий болгох, мэдээллийн технологийн аудит, эрсдэлийн үнэлгээ, менежментийг хөгжүүлэх, сүлжээ, систем, вэбсайтын эмзэг байдлыг бууруулах, адилтган таних бат бэх систем, хорт кодоос хамгаалах удирдлагыг нэвтрүүлэх;

Хүртээмжтэй байдлын чиглэлээр: тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлэх, программ хангамж, техник хэрэгслийн өрсөлдөх чадвартай үндэсний үйлдвэрлэл, шийдэл боловсруулах ажиллагааг дэмжин хөгжүүлж технологийн хараат байдлыг бууруулах;



Бүрэн бүтэн байдлын чиглэлээр: CERT болон цахим форенסיкийн тогтолцоог бий болгох, төрийн цахим мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдал, төрийн байгууллага, онц чухал дэд бүтцийн объектод чиг үүрэгт суурилсан хандалтын удирдлага, сүлжээний хяналт-шинжилгээ хийх, халдлагыг илрүүлж таслан зогсоох чадвар бий болгох замаар нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх найдвартай ажиллагааг хангах зэрэг арга замууд тогтоож өгсөн.

Кибер орчны мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болохыг олон талаар хүлээн зөвшөөрч байгаагийн илрэл нь хөрөнгө оруулалт хийх, үндэсний хэмжээнд стратеги гаргаж, хэрэгжүүлэх, хууль, эрх зүйн орчноо боловсронгуй болгон, техник технологи, хүний нөөцөө бэхжүүлж буйгаас харж болно. Тухайлбал, сүүлийн 20 жилийн хугацаанд дэлхийн 127 орон цахим аюулгүй байдлаа хангах үндэсний стратеги баталж, АНУ, ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ, Япон, Хорват, Унгар, Гүрж, Литва, Латви, Сингапур, Эстони зэрэг улс энэ чиглэлээр бие даасан хуультай болжээ. Энэ нь эдгээр улсын

Цахим технологийн эринд хүмүүс мэдээллийн асар их урсгал дунд аж төрж буй тул аюулгүй байдлын асуудал хүн бүрд хамаатай болжээ.

Зураг 19. Мэдээллийн аюулгүй байдал



АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ
НИЙГЭМ

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

кибер аюулгүй байдлын хувьд илүү эрсдэлгүй гэж үнэлэгдэхэд хүргэж буйг дээр дурдсан үзүүлэлтээс харж болохоор байна. Тодруулбал, уг жагсаалтыг Грек, Чех, Эстони тэргүүтэй Европын орнууд тэргүүлж, Ази тивээс БНСУ, Сингапур 4, Малайз 5 дугаар байрт бичигдсэн нь хамгийн дээгүүр үзүүлэлт юм.

Монгол Улсын төрийн байгууллагуудын интернэтийн сүлжээнд хийсэн шалгалтаар гадаадын 40 орчим улсаас хоногт дунджаар 9,900 удаа маш өндөр, 8,000 орчим удаа өндөр түвшний цахим халдлага бүртгэгддэг бөгөөд дийлэнх хувийг Хятад, ОХУ, АНУ, Герман улсад бүртгэлтэй хостуудаас мэдээлэл хулгайлах зорилгоор халдсан болохыг тогтоосон байна. Мөн Үндэсний дата төвд байрладаг мэдээллийн системүүд рүү чиглэсэн зорилтот халдлага 2013 оноос эрчимжсэн.

Олон улсад цахим засаглалаараа үлгэр жишээ болдог Эстони улсын хувьд мэдээллийн аюулгүй байдлаа Цахим харилцааны, Хувь хүний мэдээлэл хамгаалах, Нийтийн мэдээллийн болон Цахим аюулгүй байдлын тухай гэсэн багц хуулиар зохицуулдаг аж. Мөн тус улсын Эдийн засаг, мэдээлэл харилцааны, Батлан хамгаалах, Хууль зүйн, Дотоод хэргийн болон Гадаад харилцааны яам нь кибер аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгжтэй байна. Цагдаагийн газрын бүтцэд ч цахим гэмт хэрэгтэй тэмцэх алба ажилладаг. Түүнчлэн мэдээллийн аюулгүй байдлыг хангах бодлогын баримт бичгүүдийг уялдуулсан стратегийн хэрэгжилтийн тайланг Эдийн засгийн яамнаас нь жил бүрийн тавдугаар сард багтаан Засгийн газартаа танилцуулж, үйл ажиллагаагаа сайжруулах саналууд сонсон, шинэчилж иржээ. 2009 оноос Эстонийн Засгийн газрын Аюулгүй байдлын хорооны дэргэд байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих, кибер аюулгүй байдлыг


Зураг 20. Технологийн дэвшлийг эрсдэл багатай даван туулах арга зам

ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ЭРСДЭЛ БАГАТАЙ ДАВАН ТУУЛАХ АРГА ЗАМ БУЮУ ХЯНАХ ТОХИРГОО





Зураг 21. Мэдээлийн аюулгүй байдлын хууль, эрх зүйн үндэс



хангах зорилтын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй Кибер аюулгүй байдлын зөвлөл байгуулагдсан байна. Үүнээс гадна тус улсын Батлан хамгаалах яам, хувийн хэвшлийнхэн болон бусад салбарынхан Кибер нэгжийг байгуулсан нь өндрөөр үнэлэгдэж байна. Мөн Мэдээллийн системийн газар нь мэдээллийн систем хоорондын хамаарлыг тогтоож, эрсдэлийг үнэлэх замаар нийгэм, эдийн засагт нөлөө үзүүлэхүйц, онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууллагыг тодорхойлон, тэдгээрт тавигдах аюулгүй байдлын шаардлагыг боловсруулан, мөрдүүлдэг аж.

Манай улсын хувьд эдгээр хуулиас гадна Эрүүгийн, Зөрчлийн, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн, Хувь хүний нууцын, Байгууллагын нууцын, Төрийн болон албаны нууцын, Төрийн албаны, Хүүхдийн эрхийн, Хүүхэд хамгааллын, Садар самуун явдалтай тэмцэх тухай зэрэг хуульд цахим гэмт хэрэг, зөрчлийн талаарх зохицуулалтыг тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хэмжээнд төрийн байгууллагын кибер аюулгүй байдлыг тухайн байгууллага өөрсдөө хариуцан ажиллаж байна. Кибер аюулгүй байдлын тухай хуулиар иргэд болон онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн кибер аюулгүй байдлыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэдэх Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдийн кибер аюулгүй байдлыг Тагнуулын байгууллагын дэргэдэх Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв хариуцан ажиллахаар тогтоосон билээ.

Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргадаг Кибер аюулгүй байдлын үзүүлэлтээр манай улс 2021 онд 120 дүгээр байрт жагссан нь кибер аюулгүй байдлыг хангахад ихээхэн ач холбогдол өгөх шаардлагатай байгааг илтгэж буй юм.

"Кибер орон зай" гэж интернэт болон бусад мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, тэдгээрийн ажиллагааг хангах мэдээллийн дэд бүтцийн харилцан хамааралтай цогцоос бүрдсэн биет болон биет бус талбар; "Кибер орчин" гэж мэдээлэлд хандах, нэвтрэх, цуглуулах, түүнийг боловсруулах, хадгалах, ашиглах боломж олгож байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний орчныг хэлнэ.

АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ
НИЙГЭМ

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ


Түүнчлэн интернэтийн хорт код буюу вирусийн эсрэг программ хангамж үйлдвэрлэгч “Kaspersky” компаниас жил бүр гаргадаг аюулгүй байдлын тайланд, тус компанийн хэрэглэгч дэлхийн 80 орчим орноос “хорт кодоод өртсөн” гэсэн ангиллын 2017 оны жагсаалтад Монгол Улс тавдугаар байранд орж байжээ.

Орчин үеийн техник, технологийн дэвшил хөгжлийн шинэ боломж олгохын зэрэгцээ нийгмийн бусад сөрөг үзэгдлүүдийг ч дагуулсаар байна. Тэдгээрийн нэг нь “цахим” гэмт хэрэг юм. Энэхүү гэмт хэргийн талаар олон тодорхойлолт байдаг ч “компьютер болон цахим сүлжээ ашиглаж бусдын эд хөрөнгө, алдар нэр, хувийн нууц, аюулгүй байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд нь хууль бусаар халдаж буй өөр өөр төрлийн гэмт хэргийн нийлбэр” хэмээн хамгийн энгийнээр тайлбарлаж байна.

Улс орнууд цахим гэмт хэрэгтэй тэмцэх явдлыг чухалчлан үзэж байгааг үүнд зарцуулж буй өртөг, зардлын хэмжээ тодорхой илтгэнэ. АНУ-ын хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон шинжээчид цахим аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд 17.4 тэрбум ам.доллар шаардлагатай хэмээн үзсэн байна. Мөн олон улсын цахим аюулгүй байдлын зах зээлийн судалгаагаар, 2017-2021 онд цахим аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулагдах нийт хөрөнгө 1.0 их наяд ам.доллароос давсан бөгөөд цахим аюулгүй байдлын мэдлэг олгох сургалтын зардал л гэхэд 2027 онд 10 тэрбум ам.долларт хүрнэ гэж тооцжээ.

Зураг 22. Технологид тавигдах шаардлага

ТЕХНОЛОГИ БУЮУ ХИЙМЭЛ ОЮУН УХААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА



ТОГТВОРТОЙ
НАЙДВАРТАЙ



АЮУЛГҮЙ



ХҮРТЭЭМЖТЭЙ
ШУДАРГА



КИБЕР ЦЭРЭГ

Кибер аюулгүй байдлын тухай хуулиар батлан хамгаалах салбарын мэдээллийн системд чиглэсэн кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, зөрчилд өртсөн мэдээллийн системийг нөхөн сэргээх үйл ажиллагааг Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлыг хангах байгууллагын дэргэдэх Зэвсэгт хүчний төв хариуцахаар тогтоосон.

Дэлхий дахин 2010 оноос хойш цахим халдлагаас хамгаалах эрх зүйн хөгжүүлэлтэд ихээхэн анхаарал хандуулах болж, НҮБ-д бүртгэлтэй 195 орноос 67 нь кибер цэрэгтэй болсон байна. Энэ нь кибер хил хязгаараа хамгаалах, үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээллийн технологийг батлан хамгаалах салбарын хүний нөөц бэлтгэх, техник технологийн боломжийг нэмэгдүүлэх олон давуу талыг дэлхийн армийн бие бүрэлдэхүүнд авчирсан орчин цагийн цоо шинэ цэргийн бүтэц юм. Түүнчлэн 2020 онд гэхэд дэлхий нийтээр коронавирусийн халдварын эсрэг тэмцэж, албан байгууллагын хурал цуглаан онлайнаар зохион байгуулагдаж, зайнаас ажиллах шаардлага нэмэгдсэн нь кибер халдлага үйлдэгчдийн хувьд ихээхэн боломж болсон бөгөөд зөвхөн АНУ-д гэхэд үүлэн тооцоолол дээр суурилсан аюулгүй байдлын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Zscaler” компанийн судалгааны баг 2020 оны нэгдүгээр сараас есдүгээр сарын хооронд 6.6 тэрбум халдлага илрүүлсэн байна. Иймд цаашид дэлхийн хэмжээнд кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүдийн эрэлт эрчимжих бөгөөд зөвхөн 2020 оны ажлын байрны өсөлт гэхэд 2019 оныхоос 25 хувиар 3.5 сая хүн болж нэмэгджээ.



Монгол Улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль 2022 оны тавдугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.



Хүснэгт 2. Монгол Улсын кибер аюулгүй байдлын үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хангагдсан байдал 0-100 хувь	Олон улсад эзэлж байгаа байр
1	Үндэсний Кибер аюулгүй байдал	18,18%	125
2	Дэлхийн Кибер аюулгүй байдалтай холбогдох	26%	120
3	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжил	50%	91
4	Сүлжээний бэлэн байдал	43%	89

Эх сурвалж: NCSI Project Team, 2022

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, төрийн албан хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацыг ашиглах чадавхыг дээшлүүлнэ. Үндэсний мэдээллийн болон кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоо бий болгох, онц чухал мэдээллийн дэд бүтцийн хамгаалах, эрсдэлийн үнэлгээ, менежмент, халдлага илрүүлэх, таслан зогсоох, хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлнэ.

Зураг 23. Кибер аюулгүй байдлын үзүүлэлт

ДЭЛХИЙН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ						
ЭРЭМБЭ	УЛС	КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ		ЦАХИМ ХӨГЖЛИЙН ТҮВШИН		ЗӨРҮҮТЭЙ БАЙДАЛ
1.	 ГРЕК	96.10		64.47		31.63
2.	 ЛИТВА	93.51		68.61		24.90
3.	 БЕЛЬГИ	93.51		75.34		18.17
4.	 ЧЕХ	92.21		69.86		22.35
5.	 ЭСТОНИ	90.91		76.51		14.40
6.	 ГЕРМАН	90.91		81.43		9.48
7.	 ПОРТУГАЛ	89.61		68.25		21.36
8.	 ИСПАНИ	88.31		73.92		14.39
9.	 ПОЛЬШ	87.01		66.61		20.40
10.	 ФИНЛАНД	85.71		79.64		6.07
125.	 МОНГОЛ УЛС	18.18		46.41		-28.23

Эх сурвалж: NCSI Project Team, 2022



ИРГЭДИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦ



Тоон гарын үсгийн нийтийн түлхүүр дэд бүтцийг хөгжүүлж, тоон гарын үсгийг бүх нийтийн хэрэглээ болгож, тоон гарын үсэгт суурилсан цахим үйлчилгээний нууцлал, хамгаалалтыг хангана. Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлнэ.

Зураг 24. Цахим гарын үсгийн тухай хууль



Эх сурвалж: МУИХ, 2021

ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Их Хурал. (1992). Монгол Улсын Үндсэн хууль. УБ.
- Монгол Улсын Их Хурал. (2016). Зэвсэгт хүчний тухай хууль. УБ.
- Монгол Улсын Их Хурал. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.
- Монгол Улсын Их Хурал. (2020). "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020 оны 52 дугаар тогтоол. УБ.
- Монгол Улсын Засгийн газар. (2021). "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн танилцуулга. УБ.
- Дэлхийн эдийн засгийн форум. (2022). Visualized: A global risk assessment of 2022 and beyond. <https://www.weforum.org/agenda/2022/02/global-risk-assessment-climate-change-covid/>
- Зэвсэгт Хүчний Жанжин Штаб. (2022). Монгол Улсын Зэвсэгт Хүчин. Зэвсэгт Хүчний Жанжин Штаб: <https://gsmf.gov.mn/>
- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын төсөл боловсруулах Ажлын хэсэг. (2019). МОНГОЛ УЛСЫН ДНБ БА НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ-ИЙ ХЭТИЙН ТООЦОО. УБ.
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. (2022). Хүний хөгжлийн илтгэл, 2021. УБ. Хүний хөгжлийн тайлан: <https://hdr.undp.org/data-center/human-development-index#/indicies/HDI>
- Одон Орон, Геофизикийн Хүрээлэн. (2002). УБ.
- Үндэсний Статистикийн Хороо. (2022). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://1212.mn/>
- Үндэсний Статистикийн Хороо. (2022). Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан: https://www.1212.mn/tables.aspx?T-BL_ID=DT_NSO_2300_017V1
- Хил хамгаалах ерөнхий газар. (2022). Монгол Улсын хил. <http://bpo.gov.mn/content/54>
- Хүний эрхийн үндэсний комисс. (2022). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 20 дахь илтгэл. УБ.
- Цахим хөгжил, харилцаа, холбооны яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.
- GlobalFirepower.com. (2022). 2022 Military Strength Ranking. <https://www.globalfirepower.com/countries-listing.php>
- NCSI Project Team, (2022) National cyber security index. <https://ncsi.ega.ee/>
- The Global Organized Crime Index. (2022). The Global Organized Crime Index: <https://ocindex.net/>
- Statista. (2022). Length of longest international land borders worldwide. <https://www.statista.com/statistics/1103985/border-length-between-countries/>
- Vision of Humanity. (2022). 2022 Global Peace Index. Vision of Humanity: <https://www.visionofhumanity.org/maps/#/>
- World Justice Project. (2022). Rule of Law Index 2021. <https://www.gob.mx/cms/uploads/attachment/file/704367/wjp-index-21.pdf>

ТОВЧИЛСОН ҮГСНИЙ ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс	ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНАКУ	Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс	УИХ	Улсын Их Хурал
ДНХ	Дезоксирибонуклейн хүчил	ҮСХ	Үндэсний статистикийн хороо